



БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын нэр: МУБИС, Боловсрол судлалын сургууль

Хөтөлбөрийн нэр: Багш, насан туршийн боловсрол

Индекс: D011405

Агуулга

НЭГ. ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ТАЙЛАНГИЙН АГУУЛГА, ҮЕ ШАТ	3
1.1. Шинжээчийн багийн бүрэлдэхүүн.....	3
1.2. Магадлан шинжилсэн үе шат	3
ХОЁР. МАГАДЛАН ШИНЖЛЭЛИЙН ҮР ДҮН	4
ШАЛГУУР 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ	4
ШАЛГУУР 2. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	7
ШАЛГУУР 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХОЛОГИЙН НӨХЦӨЛ ...	10
ШАЛГУУР 4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	13
ШАЛГУУР 5. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА	17
ШАЛГУУР 6. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	22
ШАЛГУУР 7. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ	26
ДҮГНЭЛТ	
ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ	
СУРГУУЛИАС ИРҮҮЛСЭН АЛБАН БИЧИГ	
ХАВСРАЛТ	

НЭГ. ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ТАЙЛАНГИЙН АГУУЛГА, ҮЕ ШАТ

1.1. Шинжээчийн багийн бүрэлдэхүүн

БМИҮЗ-ийн ажлын албаны захирлын 2020 оны 1 дугаар сарын 24-ний өдрийн А/14 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсэг ажиллав.Үүнд:

- **Равдансүрэнгийн Чанцалдулам** - Хөдөө аж ахуйн их сургуулийн сургалт эрхэлсэн дэд захирал, бизнесийн удирдлагын ухааны доктор, шинжээчийн багийн ахлагч.
- **Жагдагийн Туяа** – Багш нарын мэргэжил дээшлүүлэх институтийн сургалтын байгууллагын менежментийн албаны дарга, доктор, шинжээчийн багийн гишүүн.
- **Ж.Баянцэнгэл** – Насан туршийн боловсролын Үндэсний төвийн ахлах мэргэжилтэн, шинжээчийн багийн гишүүн.

1.2. Магадлан шинжилсэн үе шат

Магадлан шинжилгээ нь гурван үе шатаар явагдсан.Үүнд:

- 1). Хөтөлбөрийн тайланг уншиж, шинжээчид урьдчилсан санал дүгнэлтээ гаргасан.
- 2). Тухайн хөтөлбөр хэрэгжүүлж буй сургууль дээр 2020 оны 05 дүгээр сарын 11-ны өдрөөс 12–ны өдрийг дуустал ажиллав.
- 3). Шинжээчийн баг нь саналаа нэгтгэж, дүгнэлтээ гаргалаа.

1). Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг судалсан байдал:

Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг шинжээчийн баг сургуульд ажиллахаас 2 сарын өмнө хүлээн авч, уншиж танилцсан. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан нь хөтөлбөрийн танилцуулга, 7 бүлэг, ерөнхий дүгнэлт, хавсралт гэсэн бүтэцтэй ерөнхий 7 бүлэг бүхий шалгуур бүрд SWOT, TOWS шинжилгээ хийгдсэн байна. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд дүн шинжилгээ хийхдээ бодит байдалд тулгуурлан боловсруулсан. Шинжээчийн баг нь тайлангийн бүтэц, бичилтийн агуулга нь магадлан итгэмжлэлийн хөтөлбөрийн шаардлага, үзүүлэлтэд нийцэж байгаа эсэх, статистик судалгааны дүгнэлт, өгөгдлийн нотлох баримтууд зэргийг нягтлан үзэж, 7шалгуурын дагуу тодруулах асуултуудыг гаргаж бэлтгэсэн. Тайланг тус тэнхимийн зүгээс боловсруулахдаа тэнхим байгуулагдсан хугацаа буюу 2014 оноос хойш мөн бие даан Багш насан туршийн боловсрол мэргэжлээр 2016 оноос хойших хугацааны бүх үйл ажиллагааг бүрэн гаргаж боловсруулсан. Үүнд: тухайн мэргэжлийн хөтөлбөрийг сайжруулахын тулд жил бүр тайлангийн хурал болон хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээнд тулгуурлан 2017, 2018, 2019 онуудад сайжруулалт хийж ирсэн.

2) Хөтөлбөр хэрэгжүүлж буй сургууль дээр ажилласан байдал:

Шинжээчийн баг 2020 оны 5 дүгээр сарын 11-ны өдрөөс 12–ны өдрийг дуустал 2 өдөр ажилласан. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын алба нь шинжээчийн багийн ажиллах хугацаа болон ажлын хуваарийг тухайн сургалтын байгууллагатай тохиролцож гаргасан. Шинжээчийн баг нь ажиллах хугацаандаа сургуулийн удирдлага, багштай уулзалтыг хийж харин оюутан, ажил олгогч, төгсөгчдийн төлөөллүүдтэй онлайн хэлбэрээр уулзалт ярилцлагуудыг хийлээ. Тухайн сургуульд ажиллах хугацаанд сургуулийн удирдлагууд, хөтөлбөрийн багш нар, анги танхим, интернет, холбогдох техник тоног төхөөрөмжөөр хангах, хөтөлбөрийн оролцогч талуудыг онлайн уулзалтад урих, сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаатай холбоотой нотлох баримтуудыг сайн бэлтгэж хамтран ажилласан. Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн

багш нар шинжээчийн багт шаардлагатай нотлох баримтуудын талаар тайлбар хийж, танилцуулан ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангасан.

3). Шинжээчийн баг нь саналаа нэгтгэж, дүгнэлтээ гаргасан байдал:

Шинжээчийн баг нь хөтөлбөрт дүгнэлт хийж нийт 58 хуудас тайланг хавсралтын хамт Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын албаны мэргэжилтэн /зохицуулагч/ Б.Оюунчимэгт хүлээлгэж өгсөн.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын албанаас зохицуулагч Б.Оюунчимэг нь хөтөлбөрийг магадлах үйл ажиллагааг сайн зохион байгуулж, бидний ажлыг хөнгөвчилсөнд багийн зүгээс талархал илэрхийлж байна.

ХОЁР. МАГАДЛАН ШИНЖЛЭЛИЙН ҮР ДҮН

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулж ирсэн байна.

1.1.Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
1.1.	Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.	Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ хийдэг Хөтөлбөрийн ажлын төлөвлөгөө, бенчмарк, судалгааны танилцуулгатай. Харин PEST, STEEP шинжилгээг хийгээгүй. - Гадаадын 7 сургуулийн хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгааг хийсэн.	- Хөтөлбөрийн нийгэм сэтгэл зүй, танин мэдэхүйн үндэслэлийг өөрийн орны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тодорхойлж өгсөн. - Сургалтын хөтөлбөрийг тооцон гаргахдаа олон улсын жишигт нийцүүлэн 4 чиглэлээр тодорхойлсон. - Насан туршийн боловсрол нь үндэсний хэмжээний боловсролын бодлого, дэлхийн боловсролын форм: Инчоны тунхаглал боловсрол-2030 /бүх нийтийн боловсрол 5 зорилт, дэд зорилт/ -д тулгуурлан сургалтын агуулгаа тодорхойлсон. - МУБИС –н цаашдын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн анхны төгсөгчдөөр сургалтын агуулгад өөрийн үнэлгээ SWOT шинжилгээ хийлгэсэн. - Сургалтын хөтөлбөрийг гаргахдаа гадаадын 4 их сургуулийн сургалтын агуулга судалсан.	- –Хөтөлбөрийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний талаар тандан судалгаа хийх; - Ирээдүйн чиг хандлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох хандлагын STEEP, PEST шинжилгээ хийх;

1. Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ, ажлын

төлөвлөгөө, бенчмарк, судалгаа /PEST, STEEP / хийсэн байдал:

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох зорилгоор ажил олгогч, мэргэжлийн байгууллагын ажилтан, албан бус насан туршийн боловсролын төвийн багш нараас хэрэгцээний судалгааг авч ажилладаг. Насан туршийн боловсрол хөтөлбөрийн талаар хэлэлцүүлэг нэг удаа 2018 онд зохион байгуулсан ба мэргэжлийн байгууллагын 55 төлөөлөл оролцож хөтөлбөрийг сайжруулах талаар зөвлөмж гаргаж ажилласан сайшаалтай.

- 2. Гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, бенчмарк хийсэн байдал:** Гадаад орны их, дээд сургуулийн ижил төрлийн хөтөлбөрүүдийн талаар судалсан. Тухайлбал, АНУ-ын Пэнсивилани мужийн насанд хүрэгчдийн мэргэжилтний эзэмшсэн мэдлэг, ур чадвар, ХБНГУ-ын Curriculum globale for Global Adult Learning & Education, Европын холбооны улсуудын насан туршийн хөтөлбөрүүд, University of New Brunswick, Bachelor of education in Adult Education, LifeLifelong learning education in korea, Adult Education program Standarts Callifornia зэрэг сургуулийн хөтөлбөрийг судалж хөтөлбөрөө сайжруулахад ашигласан байна.

Сайжруулахад анхаарах асуудал:

- Гадаадын их, дээд сургуулийн ижил төрлийн хөтөлбөртэй харьцуулсан судалгааны дүнгээр хөтөлбөрийг хэрхэн сайжруулж ажилласан тухай мэдээллийг цаг тухай бүрд нь гаргаж ажиллах;
- Хөтөлбөрийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний талаар тандан судалгааг хийх талаар төлөвлөлт хийж хөтөлбөртөө тусган сайжруулалт хийдэг байх;
- Хөтөлбөрөөр төгсөгчийн ирээдүйн мэргэжлийн чиг хандлага, эзэмших мэдлэг, ур чадварт нь анхаарч STEEP, PEST зэрэг шинжилгээг хийдэг байх;

1.2. Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
1.2.	Хөтөлбөрийн зорилго Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.	-Хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг сайжруулах шаардлагатай. -Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон. -Хөтөлбөрийн талаар олон нийтэд цахим хуудсаар дамжуулан мэдээлдэг.	-Хөтөлбөрийн зорилгод байгууллагын зорилго/ сургууль, тэнхим, хөтөлбөрийн зорилго/ тодорхой тусгасан. -НТБ –н хөтөлбөрийн үр дүн /PLO/, хичээлийн үр дүн /CLO/-д стандарт хазайлтыг тодорхойлж өгсөн. -Стандарт хазайлтад суурилан хувь хүний суурь чадвар, багш боловсролын дундаж, мэргэжлийн дундаж тус бүрийг гаргаж, дүгнэлт хийсэн. -Төгсөгчийг төгсөөд ажиллах АБТ-д дүйцүүлэн эзэмших суурь чадваруудыг тодорхойлж өгсөн.	-Хөтөлбөрийн зорилгыг тодорхой болгох -Хөтөлбөрөөр төгсөгчийн загварын байдал, сайжруулалт хийгддэг талаар тусгах

- 1. Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар боловсруулсан байдал:** МУБИС-ийн хувьд хөгжлийн бодлогын хүрээнд шинэ зууны багшийн загварыг боловсруулсан уг загварт үнэт зүйл, хандлага, суурь чадамж, академик чадамж, багш мэргэжлийн чадамж гэж тодорхойлсон байна. Хөтөлбөр нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын “насан туршийн боловсролын үйлчилгээний төрөл, хэлбэр, сургалтын байгууллагыг

бэхжүүлнэ” гэсэн заалт, Насан туршийн боловсролын үндсэн чиглэл болох гэр бүлийн боловсрол, иргэний боловсрол, ёс суртахуун-төлөвшлийн боловсрол, гоо зүй-мэдрэмжийн боловсрол, амьдрах ухааны боловсрол олгох гэсэн таван чиглэлийн хүрээнд сургалтын агуулгаа тодорхойлсон.

2. **Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг:** БСШУСЯ-ын сайдын А/174 тоот тушаалаар баталсан бакалаврын хөтөлбөрт тавигдах шаардлагын дагуу баримт бичгийг боловсруулсан. Хөтөлбөрийг сүүлийн таван жилийн хугацаанд 2 удаа шинэчилсэн. Тухайлбал, **2016 оны хувьд:** Суралцагчийн үйл ажиллагааг суралцагч бүрийн хөгжлийн ялгаатай байдал, онцлогт үндэслэн шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах суурь мэдлэг, чадвар эзэмшсэн түүнийгээ практикт хэрэглэх хүсэл эрмэлзэлтэй бүтээлч суралцагч болон өөрийгөө байнга хөгжүүлэх сэтгэлгээтэй багш мэргэжилтнийг бэлтгэхэд хөтөлбөрийн зорилго оршино гэж тодорхойлон **11 дэд зорилтуудыг гаргасан байна. 2018 онд шинэчилсэн хөтөлбөрийн хувьд хөтөлбөрийн** хүрэх үр дүнг гаргасан 3 эрэмбээр нарийвчлан тодорхойлсон. Тухайлбал, Хувь хүний суурь мэдлэг, ур чадвар, хандлага, Багш боловсролын мэдлэг, чадвар, хандлага, насан туршийн боловсролын мэдлэг, ур чадвар, хандлага гэж тодорхойлжээ.



Зураг 1. Шинэ зууны багшийн загвар

Ололт амжилт:

1. Насан туршийн боловсрол цахим хуудас болон нүүр хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээллийг хүргэдэг.
2. Хөдөө орон нутгийн хувьд төгсөгч ажил олгогч болон олон нийтэд MUBIS-BOSS-NTB 18 аймгийн насан туршийн боловсролын хэсэгт холбогдсон байна.

Анхаарах асуудал:

1. Хөтөлбөрийн төгсөгчийн загварыг гаргаж, агуулгын хувьд хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй холбож ажиллах;
2. Хөтөлбөрийн зорилгыг тодорхой болгох;
3. Төгсөгчийн цогц чадамжийн гарын авлага боловсруулан олон нийтэд сурталчлах.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
1.3.	Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.	-Батлагдсан хөтөлбөр, -Хурлын тэмдэглэлтэй. -Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график -Батлагдсан хичээлийн хөтөлбөрүүдтэй.	-БСШУ-ны сайдын баталсан бакалаврын нэгдсэн хөтөлбөрт тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулсан. -Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн PDCA циклийг тодорхойлж өгсөн. -Сургалтын төлөвлөгөөнд 3 удаа үнэлгээ хийж сургууль багш оюутны санал үндэслэн 2018 онд сургалтын төлөвлөгөө бүтэц батлан гаргасан. -Суралцахуйн удирдамжийн цогц чадамж, суралцахуйн үр дүнгийн тоон хамаарлын харьцааг гаргасан. -Хөтөлбөр төлөвлөлтийн өөрийн үнэлгээний тайланд SWOT, TOWS шинжилгээ хийж ажилласан.	- Хөтөлбөрийн оролцогч талуудаар хэлэлцүүлж сайжруулсан байдлыг тоо баримттай тусгах

1. **Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгийн төлөвлөлтийн байдал:** Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгийн бүрдэл нь дараах баримтуудыг оруулсан байна Үүнд: а). БСШУСЯ-ны сайдын А 174 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрийн иж бүрэн баримт бичиг боловсруулсан сүүлийн таван жилийн хугацаанд 2 удаа шинэчилж сайжруулсан. Сургалтын нэгдсэн төлөвлөгөөтэй түүний дагуу үйл ажиллагаа тогтмол хэрэгждэг.
2. **Батлагдсан хичээлийн хөтөлбөрүүд:** Тухайн хөтөлбөрт нийт 80 хичээлийн стандарт хөтөлбөр боловсруулагдсан. Нэгж хичээлийн үр дүн нь тухайн хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй холбогдож чадсан. 2018 оных нийт 80 хичээлтэй нийт 124 кредит цаг байна. Үүнээс ерөнхий суурь- 26, багш боловсролын суурь- 17, мэргэжлийн суурь- 33 хичээлийн хөтөлбөрүүд нь батлагдсан. Багш мэргэжлийн дадлагын дэвтэр бүхий удирдамж 2 удаа шинэчлэгдсэн байгаа нь хөтөлбөрийг сайжруулахад анхаарч байгаа нь харагдсан.
3. **Хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл** Хөтөлбөрийн агуулгад тасралтгүй сайжруулалт хийгдсэн ба түүнтэй холбоотой мэдээлэл бүхий хурлын тэмдэглэл, холбогдох бусад баримт бичигтэй. Харин мэргэжлийн хорооны хөтөлбөрийн стратеги төлөвлөлтийн баримт бичиг байхгүй байгааг анхаарч ажиллах шаардлагатай.

Хүснэгт 1. Хөтөлбөрийн баримт бичгийн өөрчлөлт сайжруулалт

Хөтөлбөрийн баримт бичгийн бүрдүүлэлт	2014	2015	2017	2018	Тайлбар
Хөтөлбөрийг баталсан тушаал		2015.08.19 A/153 тоот тушаал 120 кредит			
Хөтөлбөрийг өөрчилсөн тушаал			2017.11. 20 A/ 286 тоот тушаал	2018.12.18 A/153 тоот тушаал 120 кредит	
Тусгай зөвшөөрөл	2014.05.14 ний өдрийн A/208 тоот тушаал				Тусгай зөвшөөрөлтэй.
Хөтөлбөрийн хорооны төлөвлөлт баримт бичиг	2014. A/165 тоот тушаал		2017.11. 20 A/ 286 тоот тушаал		ХЕХ, Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн салбар хороо, тэнхмийн дэд хороо гэсэн зохион байгуулалттай, Бүх шатны хөтөлбөрийн хороодод ажил олгогч, төгөсөгчдийн төлөөлөл байхгүй.

Анхаарах асуудал:

1. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгийг цэгцтэй сайн төлөвлөж хэрэгжүүлэхэд анхаарах;
2. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн PDCA циклийг тодорхойлсон төлөвлөлтийн дагуу сайн хэрэгжүүлж ажиллах.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ШАЛГУУР 2. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл


Шалгуурыг хангасан байдал : Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
2.1.	Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.	<ul style="list-style-type: none"> - Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц - Удирдлагын мэдээллийн систем сайн ажилладаг. - Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээтэй. - Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлантай. - Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан графиктай. - Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаатай. 	<ul style="list-style-type: none"> • Хуульд өөрчлөлт орсны дараа Иргэний, Ёс суртахууны, Гоо зүйн боловсрол хичээлийг заавал судлах хичээл болгосон. • Хөтөлбөрийг өөрийн үнэлэлт болон шинээр гарч буй дүрэм журамд нийцүүлэн 3 жил дарааллан сайжруулсан. • Суралцагчийн суралцах боломжийг давхар мэргэжил эзэмших, магистрын зэрэгтэй төгсөх, багшаа сонгох, өөр ангиас шилжин орж суралцах, санхүүгийн болон цагийн боломжийг шийдэх талаар шинжилгээ хийж өгсөн. • Оюутны дадлага ажлын ялгаатай байдал хамтран ажилласан багшийн талаарх дүгнэлт хийдэг. • Хичээл хоорондын залгамж холбоог агуулгын босоо болон хөндлөн холбоонд суурилан улирлаар схемчлэн гаргасан. Сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээг хийж ажилладаг нь сайшаалтай. 	Сургалтын төлөвлөгөөнд хийсэн шинэчлэлт, сайжруулалтад хийсэн дүгнэлтээ баримтжуулдаг байх.

- 1. Хөтөлбөрийн болон хичээлийн үр дүнгийн матрицын хувьд** Хөтөлбөрийн индекс нь тусгай зөвшөөрлийн дагуу байгаа бөгөөд суралцахуйн үр дүн нь сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, сургалтын төлөвлөгөө, зарим хичээлийн хөтөлбөрт туссан байдлыг тодруулахад хөтөлбөрийн хүрэх үр дүндээ нийцүүлэн матриц хийж ажилладаг нь нотлогдсон./Хөтөлбөрийн А/174 тоот тушаалын дагуу боловсруулагдсан/
- 2. Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтуудын байдал:** Оюутнуудын хувьд хичээлээ өөрөө сонгох, багшаа сонгох эрхтэй. Сургалтын төлбөрийн мэдээлэл гаргах боломжтой. Оюутанд чиглэсэн нэмэлт мэдээллийг сургалтын албанаас оруулдаг. Хөтөлбөрийн зүгээс мэргэжлийн оюутнуудад зориулсан мэдээлэл хүргэх боломжтой. Оюутны сэтгэл ханамжийн судалгааг авдаг. Хичээл сонгох болох тухайн хичээлийн дүн гарах үед авдаг. Багшийн хувьд удирдлага мэдээллийн систем хичээлийн хуваарь харах, цахим журнал хөтлөх, дүнгийн тархалтын хувьд харах боломжтой, санал хүсэлт, судалгаа авах боломжтой. Удирдлагын мэдээллийн систем нь нийт 3 удаа шинэчлэгдсэн. Одоо хэрэглэж байгаа системийн нэр нь ULMS

нэртэй бөгөөд 2014 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Тэнхимийн эрхлэгчийн хувьд багшийн цаг тооцооны нэгтгэл, онлайн цахим хичээлийн нэгтгэл, цаг тооцох зэрэг мэдээллийг удирдлагын мэдээллийн системээс харах харах боломжтой. /ULMS систем/

3. **Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний хувьд** 3 удаа шинэчлэгдсэн. Сургалтын төлөвлөгөөний шинэчлэлийг дараах зураг 1-ээс харахад лекц, практикийн кредитийн хэмжээ өссөн харин семинарын хичээл буурсан нь харагдаж байна.



Зураг 1. Кредитийн хуваарилалтын харьцуулалт

4. **Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ хийсэн байдал:** Энэ хөтөлбөрөөр суралцагчид нь хөдөө орон нутаг, дүүргийн насан туршийн боловсролын төв, нэгжид дадлага хийх боломжтой. Суралцагчийн хувьд 1-р ангид: танилцах дадлага, 2-р ангид: судлах дадлага, 3-р ангид: дагалдан суралцах дадлага, туршин заах дадлага, 4-р ангид: багшлах дадлага гэж тус тус хийдэг байна. Хөтөлбөрийн хувьд гадаад, дотоодын хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байгаа. Дотоодын Дорнод ИС, Архангай БС, Ховд их, Завхан ИС-тай зайнаас багш нарын мэргэжил дээшлүүлэх чиглэлээр хамтран ажилладаг. Суралцагчийн хувьд их сургуулийн гэрээ хийсэн байгууллагатай хамтран ажилладаг. Үүнд: ЕБС, нийслэл, дүүрэг, орон нутгийн албан бус, насан туршийн боловсролын төв нэгжүүд, сургалт, судалгааны чиглэлээр 6 байгууллагатай хамтран ажилладаг.
5. **Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/ - ийн хувьд** МУБИС-ийн гарааны багшийн хүүхдэд ээлтэй хүнлэг ёс зүйтэй байх, хувь хүний болон нийгмийн, сэтгэл судлал, сургалтын арга зүй, суралцахууд хөтлөх багш мэргэжлийн чадамж эзэмших нийт 59 мэдлэг, чадвар эзэмших хичээлүүд насан туршийн боловсролын 48 мэдлэг чадвар хандлага үзэхээр уялдаа холбооны график дүрслэлийг гаргасан байна.
6. **Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгааны байдал:** Суралцагчийн цагийн ачаалал нь тухайн оюутан нэг улиралд 15-17 кредит цаг тооцдог. Долоо хоногт дунджаар 6-8 цаг байдаг. Оюутны эрэлт хэрэгцээнд тулгуурлан 4, 3.5, 4.5 жилээр сурах сонголт өгдөг. Хэрвээ 3.5 жилд сурна гэвэл нэг улиралд 17 кредит сурдаг. Завсрын улиралд хичээлээ нөхөж үзэх боломжтой.

Хүснэгт 1. Багш, насан туршийн боловсрол хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний бүтэц

Хичээлийн төрөл	Заавал судлах		Сонгон судлах		Нийт судлах	
	кредит	хувь	кредит	хувь	кредит	хувь
Ерөнхий суурь	21	17.2	4	3.0	25	20.2
Багш боловсролын	20	16.4	4	3.0	24	19.4
Дадлага			3	2.42	3	2.42
Мэргэжлийн хичээл	60	49.8	12	10.1	72	58
Нийт	104	81.4	20	18.6	124	100

Сургалтын төлөвлөгөөний хичээлийн лекц, семинарын харьцааг харахад лекцийн хичээл буюу онолын хувьд 38.8 хувь, практик дадлага цаг 61.2 хувийг эзэлж байна.

Зөвлөмж:

1. Хөтөлбөрийн хувьд насанд хүрэгчдэд хичээл заах багш нарыг бэлтгэх хөдөлмөрийн зах зээлийн эрэлт их байгаа тул хөтөлбөрийн хувьд 2.5 жилээр, бакалаврын анги төгссөн, хөрвөх сонирхолтой мэргэжилтэнд зориулсан хөтөлбөр байж болох талтай байна.

2.2.Сургалтын арга зүй

Шалгуурыг хангасан байдал : Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
2.2.	Сургалтын арга зүй Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.	-Сургалтын аргазүйг хэрэгжүүлэх загвар, заавар бүхий гарын авлагатай. -Сургалтын аргазүйд хийсэн анализ судалгааны баримт материалтай.	<ul style="list-style-type: none"> • Сургалтын арга зүйд жил бүр сайжруулалт хийдэг байна. • Цогц чадамжид суурилсан суралцагч төвтэй. • Сургалтын 5E зарчмыг баримталдаг. • Сургалтын арга зүй хэрхэн хэрэгжиж үр дүнд хүрч байгааг багш бүрээр үнэлж судалгаа гаргасан. • Багш нарын хичээлийн арга зүйг технологийн өөрчлөлтөөр гаргаж хичээлийн агуулга хоорондын давхцлыг гаргасан. 	<ul style="list-style-type: none"> • Сургалтыг хөтлөн явуулах дизайн төлөвлөлт түүний үр дүнд анализ хийж зөвлөмжийг өгсөн тухай тоо мэдээлэл дутмаг

1. *Сургалтын аргазүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж* : Сургалтыг хөтлөн явуулах нэгж хичээл бүрийн стандарт хөтөлбөрийг дагалдсан сургалтын хэрхэн зохион байгуулах явуулах багшийн гарын авлага зөвлөмжтэй бөгөөд уг баримт бичигт хичээлийг удирдан явуулах сургах арга зүйг тусгаж, тайлбарласан байгаа нь нотлогдсон.

2. **Хөтөлбөрийн сургалтын арга зүйн талаар төлөвлөсөн байдалд өгсөн үнэлгээ:** Хөтөлбөрийн болон хичээлийн үр дүн, хичээлийн онцлогоос хамааран заах арга, хэлбэрийг сайн тодорхойлж өгсөн. Тухайлбал, сургалтыг лекц, семинар, жижиг бүлгийн ажил, хэлэлцүүлгийн ажил, бие даан ажил хийх замаар явуулахаас гадна нэгж хичээлийн сургалт явуулах арга зүй нь оролцоонд суурилсан хийнгээ суралцах, холимог сургалтын арга зүй, болон цахим сургалтын арга зүйг дөлхүү хэрэглэж мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байна. Түүнчлэн оюутны хандлаг төлөвшүүлэх олон улсын 5E (engage, explore, explain, elaborate, evaluate) зарчмыг ашигладаг. Оюутнуудаас багш нарын сургалтын арга зүйд өгсөн сэтгэл ханамжийн судалгаагаар 84.4 хувь гарч байгаа нь багш нарын хувьд сургалтын арга зүйг эзэмшсэн оюутанд арга зүйг эзэмшүүлэлт сайн байгаа нь нотлогдсон */хөтөлбөрийн баримт бичиг, сэтгэл ханамжийн судалгааны үр дүн/*

2.3. Суралцагчийн үнэлгээ

Шалгуурыг хангасан байдал : Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
2.3.	Суралцагчийн үнэлгээ Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.	- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйгээ дүгнэж хэлэлцдэг. - Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын сантай. - Явцын болон төгсөлтийн шалгалтын журмын дагуу явагддаг. - Суралцагчийн голч дүн 2.6-3.1 болтлоо өсөж байгаа үзүүлэлттэй.	- Багш сургалтын үр дүнг үнэлэхдээ суралцахуйн үр дүн, хөтөлбөрийн үр нөлөөний үнэлгээгээр үнэлдэг ба үүнд рубрикийн үнэлгээний арга хэрэглэдэ. -Мэргэжлийн хичээлүүдийн үнэлгээний үзүүлэлтийг сургалтын хэлбэртэй хамааруулан тодорхойлсон.	-Хувь хүний зөөлөн ур чадварыг үнэлэх арга зүй дутмаг.

1. **Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүй, явцын болон төгсөлтийн шалгалтын журам баримталдаг байдал** хөтөлбөрөөр суралцагчийн суралцахуйн үр дүнг үнэлэхдээ Блуумын тахономи танин мэдэхүйн 6 түвшинд хийсэн даалгаврын сангаас санамсаргүй түүвэр болгох хувилбараар шалгадаг уламжлалтай. Үнэлгээ хийхдээ тухайн хичээлийн онцлог, хүрэх үр дүнгээс хамааран даалгаврыг рубрикийн аргаар шалгах, улирлын эхэнд, эцэст 2 удаа авч үр дүн, ахиц дэвшлийг гаргаж дүгнэдэг. Харин хөтөлбөрийн хувьд хөндлөнгийн үнэлгээг голчлон ашигладаг бөгөөд ажил олгогч, төгсөгч, оюутны сэтгэл ханамжийн үнэлгээг асуулга судалгааны арга, ярилцлага хэлэлцүүлгийн аргаар тодорхойлдог нь нотлогдсон
2. **Хичээл нэг бүрийн үнэлгээний хувьд** хичээл орсны дараа оюутан үнэлгээ өгдөг бөгөөд үнэлгээ нь ил тод найдвартай, шударга, ижил зарчмыг хангадаг. Хичээлийн хөтөлбөрийн үнэлгээний арга, эзлэх хувь, багтаамж нь тодорхой тусгагдсан. Оюутны вэб-ээр дамжуулан багшийн болон улирлын шалгалтын оноог тухайн оюутан болон гэр бүлийн гишүүдэд хүргэдэг үйл ажиллагаагаар нотлогдсон */Хөтөлбөрийн баримт бичиг, нэг хичээлийн төлөвлөлтийн стандарт, судалгааны баримтууд, оюутны вэб/.*

3. **Суралцагчийн сурлагын амжилт, ахицын хувьд** талаарх статистик мэдээллээс харахад сүүлийн жилүүдэд насан туршийн боловсролын оюутнуудын голч дүн нь 2.1 ээс 3.1 болтлоо өссөн байгаа нь харагдаж байна. /Оюутны вэб программ/



Зураг 1. Оюутнуудын голч дүнгийн харьцуулалт

Ололт амжилт:

1. Багш нарын үнэлгээний арга зүйн чадвар сайн;
2. Оюутны вэб-ээр дамжуулан багшийн болон улирлын шалгалтын оноог тухайн оюутан болон гэр бүлийн гишүүдэд хүргэдэг;

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1. Сургалтын орчин

Шалгуурыг хангасан байдал : Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
3.1	Сургалтын орчин Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.	-Хичээлийн байр 12, сургалтын 3 анги, лаборатори-1 той. Нэг оюутанд ногдох талбай нь 2.8 м кв. Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамж сайн 75-85 хувьтай байдаг байна.	- Сургалт зохион байгуулах лекцийн танхим, лаборатори /5 төрлийн тоног төхөөрөмж бүхий / багш нарын ажиллах өрөө нийт 20 танхимаар сургалтын орчин бүрдүүлсэн. -Сургалтын анги танхимд жил бүр засвар үйлчилгээ хийж сайжруулдаг. - Сүүлийн 5 жилээр дундажаар 495.5 сая төгрөг зарцуулсан байгаа сургалтын орчинг сайжруулахад ихээхэн анхаарч байгааг харуулж байна. - Цахим орчинд мэдээллийг хүргэх цахим орчин ашигладаг. - Удирдлага мэдээллийн системийн талаар багш албан хаагч, нараас сэтгэл ханамжийн судалгаа авч 72,4% нь маш сайн, сайн гэсэн үнэлгээ өгсөн.	-Багаар ажиллах анги танхим хомс

1. *Хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори ашиглалтын байдлыг* харахад МУБИС-ийн хувьд хичээлийн нийт 12 байртай бөгөөд уг мэргэжлийн хөтөлбөрийн хувьд 9-р байранд байрладаг. Уг хөтөлбөр лекц, семинар явуулах 3 өрөө, компьютерийн лаборатори-1, багш нарын 3 өрөөг нэмж гаргасан байна. Сургалт явуулах талбай нь 296.4 м² байгаа бөгөөд нэг оюутанд ногдох тайбай нь 2.8 м кв байна. Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлангаас харахад хүрэлцээ хангамж нь сайн. Харин оюутнуудын бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, боломж муу байна. Үүнийг оюутнуудтай хийсэн ярилцлагаас давхар нотлогдсон.
2. Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмжийн хувьд сайн бөгөөд оюутнууд цахим хичээл бэлтгэх арга зүй, мэдээллийн технологийн хичээлээс авсан ур чадвартаа сэтгэл хангалуун байгаа энэ чиглэлийн лаборатори, компьютер тоног төхөөрөмжийн хангамж сайн байгаа харуулж байна. Мэргэжлийн хөтөлбөрт зайн сургалтын төв байдгаар давуу талтай.

- Оюутны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн эмнэлгийн өрөөтэй. Оюутанд үйлчлэх алба, номын сан бүхий инновацийн төвөөр бусад хөтөлбөрийн оюутнуудын нэгэн адил үйлчлүүлдэг.

3.2.Сургалтын хэрэглэгдэхүүн

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
3.2.	Сургалтын хэрэглэгдэхүүн Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.	-Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцтэй, сурах бичгийн хүртээмж хангалтгүй. - Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж сайтай. - Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материалтай.	- Сургалтын хэрэглэгдэхүүнд олон улсын төвшинд ашиглаж байгаа программ хангамжид тулгуурлан онлайн болон хосолсон сургалтын цахим онлайн хичээлийн жагсаалт гарган боловсруулж эхэлсэн. - Багш нар хичээлээ Е-контент төвшинд боловсруулсан сургалтад ашигладаг. - Сургалтын хэрэглэгдэхүүнд төсөл хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан бүхий л хэрэглэгдэхүүнийг бүрэн боломжоороо ашиглаж байна.	-Виртуал сургалтын программ хангамж хэрэглэх судалгаа, ном гарын авлага боловсруулах, техник хангамж нэмэгдүүлэх

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгааны байдал:** Онлайн болон хосолсон сургалтын хичээлийн иж бүрэн материалууд нь багшийн хавтас болон хөтөлбөрийн баримт бичгийн хүрээнд бүрдсэн.
- Сургалтад ашигладаг программ хангамжууд болон тоног төхөөрөмжийн бүрдсэн байдал-** мэргэжлийн онцлогоос хамаарч судалгаа шинжилгээний ажил, цахим сургалтын арга зүй, сургалтын цахим хэрэглэгдэхүүн, онлайн сургалтын арга зүйн хичээлд хэрэглэх боломжтой программ хангамжийн жагсаалт /7/, тоног төхөөрөмжийн жагсаалтыг / 3,1/ хавсаргасан.
- МУБИС-н захирлын А/239 тоот тушаалаар баталсан “Сурах бичиг гарын авлагад тавигдах шаардлага” –д нийцүүлэн сургалтын хэрэглэгдэхүүн болох сурах бичгийн талаар тэнхим байгуулагдсанаас хойш багш нар нь 10 ном гарын авлага боловсруулж, бусад сургалтын 38 нэр төрлийн ном, гарын авлага ашиглаж байгааг хавсаргасан. Багш өөрийн заасан хичээлийг сиди, дивиди хэлбэрээр хувилан олшруулан сургалтад хэрэглэдэг.
- Сургалтын хэрэглэгдэхүүний талаарх сэтгэл ханамжийн** судалгаа: сургууль тэнхимийн хувьд багш нарын ажлын үнэлгээтэй хамтруулан хийдэг байсан боловч 2018 оноос МУБИС-н хэмжээнд цахим байдлаар багшийн үнэлгээг нэгдсэн байдлаар гаргаж байна. Энэ үнэлгээнд багшийг сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, ашиглах, чадвараар үнэлгээг хийж ирсэн ба үнэлгээнд багш нар 84% ба түүнээс дээш үнэлгээ авсан. Тэнхимийн зүгээс 2019 онд 16 аймгийн насан туршийн боловсролын төвд ажиллаж байгаа 28 захирал, менежер багш нараас НТБ-н талаарх тандалт судалгаа авсан байна. Энэ судалгаагаар мэргэжлийн онцлогоос хамаарч иргэд олон нийтэд сургалт явуулах тусгайлсан хөтөлбөр

байхгүй, уншиж судлах тодорхой ном гарын авлага дутмаг байгааг дурдсан байна. / ЭШХ.НТБ-н бодлого, хөгжлийн чиг хандлага .2020/.

5. **Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж:**Тэнхимийн хувьд сургалтын ажлыг зохион байгуулахад МУБИС-н захирлын 2014 оны А/221 тоот тушаалаар “Хөтөлбөрийн хорооны ажиллах журам , 2014 оны А/165 тоот тушаалаар Хөтөлбөрийн салбар дэд хороог байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэл гаргасан ба 2015 оноос МУБИС-н “Сургалтын” журам “ баталж жил бүр сайжруулалт хийж одоо 2018 оны А/376 тоот тушаалаар сургалтын журам батлагдан мөрдөгдөж байна.
6. **Е-контент төвшинд боловсруулсан сургалтын материалын хувьд** тухайн тэнхимийн давуу тал нь МУБИС дээр 2017 онд байгуулагдсан зайн сургалтын албатай нэгдсэн нь багш нар сургалтын хэрэглэгдэхүүнийг цахим байдлаар бэлтгэх бүрэн боломжтой болсон. Иймд багш нар өөрийн хичээлийг Е-контент төвшинд цахим байдлаар байрлуулахдаа судалгаанд суурилан, унших-бичвэрээр, сонсох-РРТ, хийж гүйцэтгэх-видео хэлбэрээр боловсруулж шалгалт авахаар төлөвлөн хичээлийг оруулдаг байна. Шалгалтын тест нь сонголттойгоор 2 оролттой бөгөөд өндөр оноогоор тооцохоор боловсруулсан байна.

Анхаарах асуудал:

1. Багш, насан туршийн боловсрол мэргэжил нь манай улсад цаг үеэ олсон чухал хэрэгцээ шаардлага бүхий 2 удаагийн төгсөлт хийсэн /23 төгсөгчтэй / шинэ тутамдаа хөгжиж байгаа мэргэжил юм. Иймд энэхүү мэргэжлийн үүсэл хөгжлийн суурийг тавьж байгаа тэнхимийн багш нарт /1 доктор,4докторант/ мэргэжлийн хичээл бүрийн гарын авлага сурах бичиг боловсруулж хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, зохион байгуулж байгаа сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэрэглэгдэхүүний нөөц болон материаллаг бааз техник хангамжийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа тул сургуулийн зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажлыг тогтмол нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.
2. Энэ талаар төгссөн оюутны онлайн уулзалтаар ажлын байранд очоод сургалт зохион байгуулахад сургалтын хэрэглэгдэхүүн дутмаг, ажил олгогч нартай уулзахад мөн нөлөөллийн ажилд хэрэглэгдэхүүн дутмаг, багш нарын уулзалтаас ном гарын авлага дутмаг байгаа гэсэн мэдээлэл мөн гарсан. Энэ бол тухайн мэргэжлийн онцлог болох нийгмийн олон талт ялгаатай нөхцөлд хүний сурах хөгжих үйл явцыг дэмжихэд дан ганц цахим хэрэглэгдэхүүнээс биет хэрэглэгдэхүүн зайлшгүй шаардлагатай байгааг илтгэж байна.

3.3.Сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт
3.3.	Сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.	-Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаатай. -Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа -Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа	- Сургалтын гарын авлага нь өөрийн 4 багшийн 10 гарын авлага бүрдүүлсэн. Нэмэлт байдлаар сургуулийн номын санд 350 гаруй төрлийн ном гарын авлагатай. Цахим мэдээллийн сан нээлттэй эх үүсвэрийн ашиглалт сайтай.

Ололт амжилт:

Өөрийн үнэлгээний тайланд:

- БСС нь МУБИС-ийн нэгдсэн “Удирдлага мэдээллийн систем”- ийн хүрээнд цахим нээлттэй байдлыг хангаж ажилладаг.
- Насан туршийн боловсрол, зайн сургалтын чиглэлээр 350 орчим ном сурах бичигтэй.

1.Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.

Багш, насан туршийн боловсрол мэргэжлээр 2 дахь удаагийн төгсөлт буюу 23 оюутан төгссөн бөгөөд одоогоор тухайн мэргэжлийн 6 чиглэлээр төсөл хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан гарын авлага өргөнөөр хэрэглэж байна. МУБИС-н захирлын А/239 тоот тушаалаар “Сурах бичиг гарын авлагад тавигдах шаардлага” гаргаж боловсруулсан нь багш нарын гарын авлага боловсруулахад санхүүгийн хувьд дэмжлэг үзүүлдэг нь давуу тал юм. Тэнхимийн багш нарын зүгээс нийт 10 гаруй гарын авлага боловсруулсан ба хамгийн сүүлд 2020 онд “Холимог бүлгийн сургалтын арга зүй” чиглэлээр гарын авлага боловсруулсан байна. Иймд багш нар өөрийн заасан хичээл агуулгаа цахим байдлаар боловсруулан оюутанд үйлчилж байна. Энэ чиглэлээр багш бүрийн сургалтын материалын боловсруулалт сайн гэсэн үнэлгээг сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах оюутны сэтгэл ханамжийн үнэлгээнээс нотлогдож байна. Багш нарын зүгээс тухайн шинэ тутам байгуулагдаж байгаа мэргэжлийн талаарх тулгамдсан асуудлаар олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж, хэлэлцүүлэг хийж оролцож байгааг илтгэлийн эмхтгэлээр нотолсон байна. /2020 он “Боловсролын бодлого бодлогын шинжилгээ” Багш Д.Оюунбилэг “ НТБ-н бодлого, Хөгжлийн чиг хандлага” илтгэл/ Удирдлага мэдээллийн системээ ашиглаж оюутнуудаас багш нарын үйл ажиллагаа, хичээл заасан байдал, харилцаа, оюутнуудыг дэмжиж буй хэлбэр зэрэг цахим асуулгаар санал хүсэлт авч үнэлгээ хийж байна.

2.Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа

Багш, насан туршийн боловсрол мэргэжил нь боловсруулагдсан ном гарын авлага түгээмэл байдаг нь давуу талтай. Иймд тухайн мэргэжлээр судалж ашиглах боломжит номоор сурах бичгийн баяжилт хийж өөрийн үнэлгээний тайланд хавсралтаар оруулсан байна. Насан туршийн боловсролын тэнхимийн багш нар дотооддоо Canvas программ ашиглан мэдээллээ солилцох, хөтөлбөр агуулгаа дүгнүүлэх, хийсэн бүтээлээ байршуулах зэрэг мэдээллийн нээлттэй байдлыг хангасан байна. Тус салбар сургууль нь тусгайлсан номын сангуй ч сургууль нэгдсэн номын сантай нь оюутанд үйлчлэх боломжтой.

3.Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа

МУБИС нь номын сандаа Lib4U /net version/ программ хангамжийг ашиглан интернет сүлжээнд тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд 183,932 ширхэг номыг цахим хэлбэрт оруулан ашиглуулж байна. Гадаад дотоод хамтын ажиллагааны хүрээнд олон улсын 10 орчим эрдэм шинжилгээ, судалгааны сангийн эрхийг авч Сургуулийн хэмжээнд удирдлага мэдээллийн систем сайн ажиллаж бүх багш нарын үйл ажиллагаанд хяналт тавих боломжтой болсон. Насан туршийн боловсролын тэнхимийн багш нар дотооддоо Canvas программ ашиглан мэдээллээ солилцох, хөтөлбөр агуулгаа хэлэлцэн сайжруулах, хийсэн бүтээлээ байршуулах зэрэг мэдээллийн нээлттэй байдлыг хангасан байна. Оюутнууд багшийн хичээлийн агуулга, хөтөлбөрийг цахим хэлбэрээр үнэлгээ өгч байгаа нь давуу талтай.

Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэр, түүний ашиглалтын талаар:

- Бүх багш нар цахим журнал ашигладаг.
- Оюутнууд багшийн хичээлийн агуулга, хөтөлбөрийг цахимаар үнэлдэг.
- Удирдлага мэдээллийн системээ ашиглаж оюутнуудаас багш нарын үйл ажиллагаа, хичээл заасан байдал, харилцаа, оюутнуудыг дэмжиж буй хэлбэр зэрэг цахим асуулгаар санал хүсэлт авч үнэлгээ хийдэг.
- Насан туршийн боловсролын тэнхимийн багш нар дотооддоо Canvas программ ашиглан мэдээллээ солилцох, хөтөлбөр агуулгаа дүгнүүлэх, хийсэн бүтээлээ байршуулах зэрэг мэдээллийн нээлттэй байдлыг хангасан байна.
- Насан туршийн боловсрол, зайн сургалтын чиглэлээр 350 орчим ном сурах бичигтэй.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн ном сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа байхгүй байгаад анхаарах

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ШАЛГУУР 4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
4.1.	Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.	-Хөтөлбөрийн хороо, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэлтэй. -Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй эрхзүйн баримт бичиг бүрдсэн. -Хөтөлбөрт ирсэн санал гомдлыг сайн шийдвэрлэдэг тухай тэнхимийн баримт бичгээс харсан. -Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө түүнд хийсэн SWOT шинжилгээтэй. -Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ	-Сургуулийн болон хөтөлбөрийн ерөнхий бүтэцтэй хорооны ажигладаг. -Насан туршийн боловсролын болон зайн сургалтын хөтөлбөрүүдийн уялдааг гаргаж өгсөн. -Хөтөлбөр хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичиг хичээлийн стандартууд 100% батлагдсан байна. -Хөтөлбөрт ирсэн санал гомдол нь цахим байдлаар нэгтгэн гаргасан. -Багш нарын ажлын үнэлгээг багш бүрээр гаргасан. -Мэдээллийн системийн ашиглалтыг тоон баримтаар гаргасан.	-Хөтөлбөрийн талаар хурлын тэмдэглэл, шийдвэр баримт бичиг боловсруулалт, дутмаг

- 1. Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл:** Насан туршийн боловсрол зайн сургалтын тэнхим нь 2019-2020 оны хичээлийн жилд дараах хурлын тэмдэглэл хийсэн байна. Үүнд:
 - Хөтөлбөрийн хороогоор орсон хурлын тэмдэглэл-1 / хөтөлбөрийг 3 удаагийн сайжруулалт хийсэн тул магадлан итгэмжлэлээр оруулах санал гаргасан/
 - Хөтөлбөрийн дэд хороогоор орсон хурлын тэмдэглэл-3 /хөтөлбөрт байгаа хичээлийн залгамж холбоог сайжруулах, нэмж хассан хичээлийн тэнцвэрт байдлыг хадгалах,боловсруулалтыг сайжруулах/
 - Тэнхимийн хурлыг тэмдэглэл -10 / цаг үеийн ажлууд/ нийт 14 хурлын тэмдэглэлтэй танилцсан. Хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлд тухайн хөтөлбөрийн талаарх мэдээллийг дутуу оруулсан, баримт бичиг боловсруулалт цаашид авах арга хэмжээний талаарх дүн шинжилгээ дутмаг байна.
- 2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичиг, хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ:** Багш, Насан туршийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх зүйн шаардлагатай баримт бичгийг хавтаслан / БШУС-н 2013 оны А/242 тоот насан туршийн боловсролын талаар баримтлах чиглэл, албан бус боловсролын багшийн албан тушаалын тодорхойлолт, Насан туршийн боловсролын үндэсний хөтөлбөр, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого,

Дэлхийн Инчоны тунхаглал, Насан туршийн боловсролын эрх зүйн хичээлийн хөтөлбөр, Бичиг үсгийн боловсрол олгох үндэсний хөтөлбөр/ сургалтын үйл ажиллагааг явуулж жилийн эцэст тулгамдаж буй асуудлыг илрүүлэн хэлэлцүүлж сайжруулж ирсэн тайлан хавсаргасан. Хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцдог /8 нэгж хэлтэс/ нэгжүүдийн үүрэг оролцоог тодорхой тусгаж өгсөн нь үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин бүрдсэн гэж дүгнэж байна. Эдгээр эрх зүйн баримт бичгийн хүрээнд жил бүр тэнхим ажлаа төлөвлөн хэрэгжүүлж үр дүнг тооцон, тулгамдсан асуудлыг тодруулан ажиллаж байгаа нь тэнхимийн хурлын тэмдэглэлээс харж болно.

3. **Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө түүнд хийсэн дүн шинжилгээ:** МУБИС нь сургалтын төлөвлөгөөг шинэчлэн 4 жилийн үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулдаг. Тухайн хөтөлбөрт өөрчлөлт орох бол хөтөлбөрийн дэд хороо, салбар ерөнхий хороогоор хэлэлцүүлэн батлуулж ажилладаг. Иймд төлөвлөлт нь нэгжээс эхлэн боловсруулагддаг байна. Иймээс хөтөлбөрийн хэрэгжилтийг тэнхимээр хэлэлцэн дүгнэдэг. Хөтөлбөрийн тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээтэй сүүлийн 2 жилээр танилцахад 2017-2018, 2018-2019 оны хөтөлбөр хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудал нь

- ✓ Сургалтын цахим хэрэглэгдэхүүнийг сайжруулах чихэвч, микрофон камер дутагдалтай байгаа нь хичээлийн чанарт нөлөөлж байна. Иймд техник хэрэгсэл нэмэгдүүлэх
- ✓ Багш нарыг гадаадын хэвлэл, олон улсын хуралд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажил дутмаг байна.
- ✓ Багш нарын ачаалал их байна
- ✓ Сургалтын гарын авлага, сурах бичиг боловсруулах шаардлага байна гэж тодорхойлсон байна
- ✓ Дээрх тулгамдсан асуудлыг 2019-2020 оны хичээлийн жилд хэрэгжүүлэхэд тодорхой ахиц гарган ажилласан нь: техник тоног төхөөрөмжийг / 400.000 төгрөгийн тоног төхөөрөмж/, багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад /5.890.000 төгрөг /зарцуулсан байдал, цахим сургалтын хөтөлбөр боловсруулсан байдалтай танилцсан. Цаашид сургалтын орчин сайжруулахад 2020 онд сургуулийн өргөтгөл хийх боломж бүрдсэн байна. Боловсрол судлалын сургууль ба хөтөлбөрийн ерөнхий хорооны бүтэц, үйл ажиллагааг схемчлэн гаргаж тайланд хавсаргасан. Хөтөлбөр хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичиг хичээлийн стандартууд 100% батлагдсан байна.

4. **Хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн тайлан:** 2014 оноос хойш жил оюутан суралцагчдаас сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж буй багшийн заах арга ур чадварын талаар захиа, санал асуулга гэсэн 2 хэлбэрээр санал асуулгыг цахим байдлаар авч нэгтгэн гаргасан нь тэнхимийн удирдлагын зүгээс багш нартай ажиллах боломж олгогдсон. Үнэлгээнд тэнхимийн багш нар 84-99% үнэлэгдсэн байгаа нь хөтөлбөр хэрэгжүүлэх боломж бүрдсэн ба хэрэгжилтийн талаар ямар нэг санал гомдол гараагүй байна. Энэ үнэлгээ нь сургалтын удирдлага мэдээллийн системтэй холбогдон багш нарын ажлын гүйцэтгэлийг хянах боломж бүрдсэн. Суралцагч оюутан нараас гардаг гомдол нь хөтөлбөрийн хэрэгжилт бус, сургалтын төлбөртэй холбоотой санал гомдол ирдэг байна.

5. **Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ:** МУБИС нь 2014 оноос эхлэн сургалтын чанарын шинэчлэл, бүтцийн өөрчлөлт, технологийн шинэ дэвшил сургалт удирдлагын үйл ажиллагааг дэмжих, багш оюутанд хүртээмжтэй удирдлага мэдээллийн систем (ULMS 1.0) нэвтрүүлсэн байна. Энэ нь бодит мэдээлэл дээр тооцоо судалгаа хийх боломж бүрдүүлсэн. Үүнд 6253 хичээлийн нэгдсэн сан үүсгэн ажиллаж байна. Системийн хөгжүүлэлтийг 8 систем ашиглаж байгааг тайланд тодорхой тусгасан. Энэ үйл ажиллагаа нь 14.000 оюутан, 900 гаруй багш ажилтанд нээлттэй ил тод байдлаар ашиглаж байна. Тус удирдлага мэдээллийн системийн үйл ажиллагаанд нийт багш ажилтнаас сэтгэл ханамжийн судалгаа авахад 72.4%

маш сайн, сайн гэсэн үнэлгээ өгсөн байгаа нь үйл ажиллагааг дэмжих боломжтой хэрэгжиж байна гэж дүгнэж байна.

Анхаарах асуудал:

1. Хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлд тухайн хөтөлбөрийн талаарх мэдээллийг дутуу оруулсан, баримт бичиг боловсруулалт болон цаашид авах арга хэмжээний талаарх дүн шинжилгээ дутмаг байна.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт
4.2.	Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.	-Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдтэй. -Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагддаг. -Нийгэмд насан туршийн боловсрол олгох болон багш нарт заах арга зүйн чиглэлээр сургалт явуулдаг. -Төгсөгчдтэйгээ эргэх холбоотой ажилладаг. -Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.	-Гадаад дотоод хамтын ажиллагааны хурал хэлэлцүүлгийг цахим онлайнаар хийсэн мэдээлэл оруулсан. -Дотоодын их дээд сургуулийн багш нартай судалгаа шинжилгээний ажил оюутны төгсөөд ажиллах албан байгууллага хоорондын хамтын ажиллагааг тодорхой болгон эхлүүлсэн байна. Дотоодын мэргэжлийн байгууллагатай хамтран тэднийг чадваржуулахад хамтран ажилладаг.

Ололт амжилт:

Өөрийн үнэлгээний тайланд:

- ✓ Гадаад дотоод хамтын ажиллагааны чиглэл болон давтамжийн тоог гаргасан.
 - ✓ Хамтран ажилласан байгууллагын нэрсийг тоочсон
 - ✓ Тэнхимийн хөтөлбөр хэрэгжүүлэх сургалтаас гадна зохион байгуулдаг ажлыг тодорхой бичсэн.(захиалгат сургалт, багшлах мэргэжлийн сургалт)
 - ✓ Багш нарын бусад хамтын ажиллагаа (ЕБС-н хөтөлбөрийн үйл ажиллагаа, Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт тэнхимийн оюутны эрдэм шинжилгээний сургалт)
1. *Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлагналын байдал:* Тэнхимийн гадаад дотоод хамтын ажиллагааны хувьд ОХУ, Япон улстай онлайнаар сургуулийн профессоруудын хурал туршлага солилцох үйл ажиллагааг 3 удаа зохион байгуулж, Солонгосын их сургуультай хамтран ажиллаж байна. Дотоодын 8 аймгийн НТБ төв, болон Дорнод Архангай, Ховд, Завханы их дээд сургуультай хамтын ажиллагааны хурал хэлэлцүүлгийг онлайнаар хийж, сургуулийн багш нартай судалгаа шинжилгээний ажил оюутны төгсөөд ажиллах албан байгууллага хоорондын хамтын ажиллагааг тодорхой төвшинд хүргэсэн. Мөн мэргэжлийн байгууллагууд БМДИ, НТБҮТ, ЕБС, Нийслэл,

дүүрэг, аймгийн НТБ-н төвтэй хамтран ажиллаж байна. Харин сургалт хүссэн байгууллагад насан туршийн боловсролын чиглэлээр сургалт хийж ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд холбоо тогтоох чиглэлүүдийн эхлэл тавигдсан байна. Тэнхим нь өмнө хамтран ажиллаж байсан тэнхим болон багш нарын мэргэжлийн онцлогоос хамааран дараах төсөлд багш нар ажилласан.

- 2014-2015 “Пиннингийн технологийг цөмийн технологид ашиглах нь
- 2015-2016 “Тусгай хэрэгцээт боловсролын төсөл”
- 2016-2017 “Дүйцсэн сургалтын хөтөлбөрт ТХБ-н үзэл санааг тусгах нь”
- 2017-2018 “Кавитацын микро болон нано технологийн физик үндэслэл”
- “ЕБС-ийн байгалийн ухааны хичээлийг МХТ ашиглан сайжруулах”
- 2018-2019 “Бөмсийн кластерчлал” зэрэг төслүүдэд амжилттай ажилласан байна.

2. *Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүнгийн хувьд:* Нийгэмд үзүүлсэн үйлчилгээгээр одоогоор насан туршийн боловсрол мэргэжлийг сурталчлах ажил багш бүр зохион байгуулж байна. Үүнд:

- a. Бусад байгууллага хамт олонд сургалтын үйл ажиллагаагаар тасралтгүй суралцах хэрэгцээг ханган үйлчилдэг. Үүнд БМДИ-Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт, НТБ-ын үндэсний төвийн мэргэжилтэн, төв, нэгжийн багш нарт сургалт, БСШУЯ-ны Насан туршийн боловсролын үндэс төв, дүүрэг, орон нутгийн нэгж, төвүүдэд сургалт хэлэлцүүлэг нийт 200 цаг орчим захиалгат сургалтыг байгууллага хамт олны хүсэлтээр насанд хүрэгчдийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор 18 байгууллагад нийт 845 хүнд хүргэсэн.
- b. Оюутнуудын сургалтын үйл ажиллагааны хүрээнд нийгэмд чиглэсэн үйлчилгээ үзүүлдэг. Үүнд: “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо”-ны сургалт үйл ажиллагаатай танилцуулах зорилгоор 11 оюутнууд сайн дурын гишүүнээр элсэх, төвийн сургалт болон олон нийтийн үйл ажиллагаанд сайн дурын ажилтнаар ажилладаг. “Насан туршийн боловсрол”-2019, “Боломж, тэгш эрх” 2018, 2019 онуудад нөлөөллийн үйл ажиллагаануудад нийт 48 оюутан сайн дурын ажил хийж ажиллаж байна.
- c. Багш, насан туршийн боловсролын чиглэлээр мэргэжлийн танилцуулга 650 ширхэг хийж тараасан.
- d. Цахим хэлбэрээр сургалтын 5 агуулгаар сэтгүүл гаргахаар төлөвлөж байна. Суралцаж байгаа оюутнуудын дунд суралцаж буй чиглэлээр нийгмийн ажилд тэнхимээс зохион байгуулалттай хамруулж байна.

3. *Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам мөрддөг байдал:* Багш, насан туршийн боловсрол олгох мэргэжлийн чиглэлээр багш солилцоо болон суралцагч солилцох үйл ажиллагаа нь цаг хугацааны хувьд болоогүй байна. Суралцаж байгаа оюутанд сургуулийн зүгээс захирлын нэрэмжит урамшуулал, элсэлтийн шалгалтын урамшуулал 750 оноо-100%, 650 онооноос дээш бол 70%, буцалтгүй тусламж, оюутны хөгжлийн зээл, замын зардлын тэтгэлэг зэрэг хөнгөлөлт үзүүлж байна. Үүнд: 2015 оноос хойш оюутны хөгжлийн зээлд давхардсан тоогоор 17 оюутан, буцалтгүй тусламж үзүүлэхэд давхардсан тоогоор 30 оюутан, замын зардал давхардсан тоогоор 40 оюутан тус тус хамрагдсан байна. Харин гадаад дотоодын багш, оюутан солилцооны талаар хийгдэх тодорхой хугацаа боломж бүрдээгүй байна.

4. *Төгсөгчдийн холбооны үйл ажиллагаа, төгсөгчдийн давтан сургах чиглэлээр анхаардаг байдал:* Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах боломж одоогоор гараагүй ба 2 удаагийн төгсөлтөөр 23 хүн төгсөж, 17 хүн ажлын байртай болсон.

Энэ нь төгсөгчдийн 73,9% ажлын байртай болсон. Төгсөөд ажлын байранд ажиллаж байгаа оюутантай уулзалт хийхэд одоогоор төгсөгчдийн холбоо байгуулах хэмжээний олон төгсөгчтэй болоогүй ба зөвхөн тулгамдсан асуудлын хүрээнд холбоо барьж харьцаж байна.

Анхаарах асуудал: Төрийн бус байгууллага болон гадаад дотоод хамтын ажиллагааны давтамж бага байгааг анхаарч ажиллах

4.3. Санхүүжилт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
4.3.	Санхүүжилт Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.	-Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан -Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо -Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа -Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт -Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан	- Тус сургууль нь төрийн өмчит боловч төлбөр . Нэг кредитийн үнэлгээ 71000-86000 байхаар баталгаажуулсан. - Төлбөрийн 75% салбар сургуульд, 25% нь сургуулийн хөгжлийн санд ордог. - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн нэгжийн задаргааг сүүлийн 5 жилээр гаргасан. - НТБЗС Тэнхимийн орлого зарлагыг сүүлийн жилээр гаргасан. - Багш мэргэжил захиалгат сургалтаар санхүүгийн дэмжлэг авдаг ба түүний олсон орлогыг сүүлийн 5 жилээр гаргасан.	• Сургалтын орчин сургалтын хэрэглэгдэ хүүний санхүүжилтийг нэмэгдүүлэх

Ололт амжилт:

Өөрийн үнэлгээний тайланд:

- ✓ Жил бүр сургалтын төлбөрийг удирдах зөвлөлийн тогтоолоор тогтоож зарцуулалтыг тодорхой журмын дагуу хийдэг тухай
- ✓ Боловсрол судлалын сургууль, багш насан туршийн боловсролын санхүүжилтийг 2014-2019 оноор гаргасан.
- ✓ Сургалтын төлбөрийн орлогын зарцуулалтыг 2018-2019 оноор гаргасан.
- ✓ Бусад сургалтаар олдог санхүүжилтийн задаргааг тусгасан байдал нотлох баримтаар нотлогдсон.

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын байдал:

Тус сургууль нь төрийн өмчит боловч санхүүжилтийн эх үүсвэр нь оюутны төлбөр . Нэг кредитийн үнэлгээ 71000-86000 байхаар захирлын тушаалаар баталгаажуулсан. Төлбөрийн 75% салбар сургуульд, 25% нь сургуулийн хөгжлийн санд ордог. Хөтөлбөр хэрэгжүүлэх орлого зарлага болон үр дүнг сүүлийн 5 жилээр гаргасан. 2018-2019 онд 234.70 орлоготой, зардал нь 197.30 ба 37.4 сая төгрөгний эерэг үзүүлэлттэй гарсан байна. Нэг суралцагчид оногдох өртөг зардлын тооцоо нь тухайн жилийн оюутны төлбөрөөр хамааран тогтоогддог.

2. **Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн талаар:** Хөтөлбөрийг хэрэгжүүлдэг нэгжийн задаргааг сүүлийн 5 жилээр гаргаж хавсаргасан. 2018-2019 онд 37.4 сая төгрөгний ашигтай ажилласан. Нийт орлогын 78% нь багш ажилтны цалинд, 6%- сургалт бичиг хэрэгт, ашгийн 15% хасаж үлдсэн 85% нь сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд зарцуулж байна. Санхүүгийн хувьд бүрэн хүрэлцээтэй харагдлаа.
3. **Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалтын байдал:** Сургалтын орчин сайжруулах, багш ажилтны мэдлэг чадварыг дээшлүүлэх, иргэд аж ахуйн нэгжид мэргэжил сурталчлах, захиалгат сургалт зохион байгуулах, багш мэргэжлийн сертификатын сургалт зохион байгуулахад чиглэдэг. Сургалтын орчин сайжруулахад 2014 оноос хойш 61.2 сая төгрөг, багш ажилтны мэргэжил дээшлүүлэхэд 30 орчин сая төгрөг, / нийт орлогын 0,03% байгаа ч үүнийг цаашид 1% болгоно/ тус тус зарцуулсан байна.
4. **Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын байдал:** Багш мэргэжлийн сургалт, захиалгат сургалтаар санхүүгийн дэмжлэг авдаг ба түүний олсон орлогыг сүүлийн 5 жилээр гаргасан. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн дэмжлэг, санхүүжилт байхгүй, төрийн зүгээс хийдэг санхүүжилт нь хичээл, оюутны байрны урсгал засварыг ойлгож болно. Багш мэргэжлийн сертификатын сургалт нь тухайн тэнхимийн нэг онцлог сургалт бөгөөд үүнд 2014-2019 онд нийт 217,728,000 төгрөгийн нэмэлт санхүүжилт хийгдсэн байна. Мөн бас нэг орлогын эх үүсвэр захиалгат сургалтаар нийт 5 жилд 29,940,000 төгрөгийн нэмэлт орлого олсон байна. иймд нийт сүүлийн 5 жилд оюутны төлбөрөөс гадна 789,9 сая төгрөгийн орлого олсон байна.

Анхаарах асуудал:

1. Сургалтын орчин сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах ном гарын авлага хэвлүүлэх, санхүүжилтийг нэмэгдүүлэхэд анхаарах

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
4.4.	Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.	-Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал -Хийсэн ажил, арга хэмжээ, тайлан, баримт	- Төгсөгчдийн ажиллах ажлын байрны судалгаа тандалт сайн гаргасан. - Тандалт судалгааг элсэгч нараас гадна их дээд сургуулийн эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж танилцуулах ажил зохион байгуулдаг. - Сурталчилгааг цахим онлайн байдлаар цаашид хэрэгжүүлэх санаа дэвшүүлсэн.	• Хөтөлбөрийн маркетингийн төлөвлөлтийг тогтвортой хэрэгжүүлэхэд анхаарах

1. **Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал, хийсэн ажлууд:** Багш насан туршийн боловсрол нь мэргэжлийн онцлогоос хамаарч шинэ тутам мэргэжил тул ажлын байрны тандалт судалгаагаар сайн үзүүлэлттэй гарсан. Энэ нь тус мэргэжлээр анх удаа 2 жилийн төгсөлтөөр 23 хүн төгссөн ба ажлын байрны боломж сайн. Ажлын байрны тандалт судалгааг нэгж байгууллагад хийхээс гадна их дээд сургуулийн эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж танилцуулах ажил зохион байгуулдаг байна. Мөн тэнхимийн зүгээс 2019 онд 16 аймгийн насан туршийн боловсролын төвд ажиллаж байгаа 28 захирал, менежер багш нараас НТБ-н талаарх тандалт судалгаа авсан байна. Энэ судалгаагаар насан туршийн боловсролын байгууллагад ажиллаж байгаа багш ажилтан нар богино хугацааны сертификатын сургалтад суух санал дэвшүүлсэн байна. / НТБ-н бодлого, хөгжлийн чиг хандлага ЭШХ.2019/ Харин оюутнууд мөн ажлын байранд ажиллаж байгаа багш нарт “Насан туршийн боловсрол” фэсбүүкийн хуудсаар дамжуулан өөрийн мэргэжлийн ур чадвараа ашиглан мэргэжлийнхээ онцлогийг таниулах чиглэлээр нийгэмд үйлчилгээ үзүүлж ажиллаж байна. Үүнд: боловсролын чанар үр дүн ОУЭШХ-д, “Насан туршийн боловсрол дахь олон нийтийн ойлголтыг судалсан нь”, “Албан бус насан туршийн боловсролын багшлах боловсон хүчний өнөөгийн байдал” сэдэвт илтгэлүүдийг тэнхимээс хэлэлцүүлсэн байна.

Анхаарах асуудал:

1. Хөтөлбөрийн маркетингийн төлөвлөлтийг цаашид тогтвортой хэрэгжүүлэхэд анхаарах

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
4.5.	Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.	-Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт -Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа	- Хөтөлбөр хэрэгжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор цахим мэдээллийг хэрхэн түгээж байгаа талаарх веб сайтын тандалтыг тоон үзүүлэлтээр гаргасан. - Вебсайтын мэдээлэл нь тогтмол ажиллагаатай тусгайлсан тоног төхөөрөмж бүхий зайн сургалтын тэнхимээр явагддаг.	• НТБ-ын чиглэлээр салбарын байгууллагуудтай нягт уялдаа бүхий сурталчилгааг идэвхтэй зохион байгуулах

Өөрийн үнэлгээний тайланд:

- ✓ Багш, насан туршийн боловсролын мэргэжлийн талаар түгээн сурталчилж байгаа ажлын талаар мэдээлэл хийсэн.
- ✓ Олон нийтийн мэдээллийн суваг телевизээр хийсэн мэдээллийн тухай
- ✓ Сонин сэтгүүлд хийсэн мэдээлэл
- ✓ Веб сайтын үйл ажиллагаа түүнд хандсан хандалтын талаарх мэдээлэл (1.551.712)

Ололт амжилт:

1. Тухайн хөтөлбөрийн талаарх мэдээлэл хийх үйл ажиллагааг нөөц бололцоогоо ашиглан эхлүүлсэн сайн талтай. Үүнд өөрийн байгууллага, хамтран ажилладаг байгууллага, суралцаж байгаа оюутан, хэвлэл мэдээллийн хэрэгслийг бүрэн ашиглаж байгаа нь ололттой. Одоогоор мэргэжил сурталчлахад 650 ширхэг танилцуулга хийж тараасан ба сургалтын агуулгын хүрээнд сэтгүүл хийхээр төлөвлөж байна. Мэргэжил сурталчлахад: БСШУСЯ, МУБИС, нийслэл орон нутгийн насан туршийн боловсролын төвүүдийн уулзалт хэлэлцүүлэгт байнга оролцон мэдээлэл хийх, Телевизийн нэвтрүүлгээр 2 удаа нийт 38 минутын ярилцлага, Сонин бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2 удаа , “Насан туршийн боловсрол зайн сургалтын тэнхим” Facebook, МУБИС-н Facebook, Орон нутгийн насан туршийн боловсролын төвүүдийн Facebook, МУБИС-ийн www.mnue.mnсайтаар зэрэг мэдээллийн хуудас ашиглан олон нийтэд хүргэж ажиллаж байна.
2. Мэргэжлийг сурталчлах нээлттэй ил тод болгох зорилгоор тэнхимийн багш бүр тодорхой чиглэлийг хариуцсан ажиллаж байна. Үүнд: Сургалт зохион байгуулах, Насан туршийн боловсролын төвүүдтэй болон төгсөгч нартай хамтран ажиллах, насан туршийн боловсролын ажил мэргэжилтэй холбоотой агуулга бэлтгэж мэдээлэл хүргэх, шинээр Веб сайт нээх, насан туршийн боловсролын сургалтын агуулгыг дизайнчлах, youtube суваг ашиглан нийтэд мэдээлэл хүргэх ажлууд төлөвлөж тодорхой хэмжээний биелэлттэй явагдаж байна. Эдгээр ажлыг энэ хичээлийн жилийн 2 дугаар хагаст хийхээр төлөвлөсөн байна. Мөн насан туршийн боловсролын

мэргэжил сурталчлах цогц ажил хийх хүрээнд албан ёсны домайн хаягтай болох, веб сайт үүсгэх, веб сайтын загвар боловсруулах видео бичлэг хийх, постер инфографик хийх, зэрэг ажил энэ хавар бэлэн болгохоор 2020 оны 5 сард хийж дуусгахаар төлөвлөсөн хэрэгжүүлж байна.

3. Ажил олгогчтой хийсэн хурлаар ЕБС-н төгсөх ангийн сурагчдад зориулсан видео шторк, болон мэдээлэл хэрэгцээтэй байгааг Дархан уул аймгийн ажил олгогч нар мэдээллэл өгч байсан. Мөн төгсөгч нартай уулзахад Багш, насан туршийн боловсролын мэргэжлийн талаар бусад иргэд албан тушаалтны үнэлэмж хангалтгүй байгааг дурдаж байгаа нь шинэ тутам гарч байгаа энэ мэргэжлийн хөтөлбөрийн нээлттэй ил тод байдал дутмаг байна гэж үзлээ. Мөн МУБИС-д элссэн оюутан нар эхний курсэд нэгдмэл байдлаар сургалт зохион байгуулагддаг тул элсэгч нар тодорхой мэдлэг мэдээлэлгүй тул бусад мэргэжлийн ангид элсэх тохиолдол гардаг тухай багш нартай хийсэн уулзалтаас харагдаж байна. Иймд тухайн хөтөлбөрийг ил тод нээлттэй зөвхөн мэргэжлийн байгууллага өөрийн сургууль бус нийгэмд таниулах ажил зохион байгуулахад сургуулийн тодорхой дэмжлэг зайлшгүй шаардлагатай байна.

Анхаарах асуудал:

1. Аймаг дүүргүүдэд ажиллаж байгаа насан туршийн боловсролын төвүүдтэй хамтын ажиллагааг идэвхжүүлэх, ЕБС-н сурагчдад мэргэжлээ сурталчлах ажлыг тодорхой түвшинд гаргахад чиглүүлэх шаардлагатай.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ШАЛГУУР 5. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
5.1.	Суралцагч сонгох, элсүүлэх Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.	-Элсэлтийн бодлого, дүрэм журам -Элсэгчдийн ЕШ-ын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа. -Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага -Гадаад оюутны элсэлтийн тоо	- 2014 оноос тус мэргэжлээр элсэлтийн оноо 480 ба тусгайлан хөнгөлөлт үзүүлсэн. Үүнд 750 оноо-100%, 651-750 бол 70%, хөнгөлөлт үзүүлсэн тухай тоон мэдээлэл гаргасан. - Нийт 4 жилийн хугацаанд 98 оюутан элссэн гадаад оюутан байхгүй дундаж оноо 503 байна. - Тусгайлан оюутан хариуцсан ажилтантай ба ажлын чиг үүргийг тодорхойлсон.	• Элсэлтийн тоог нэмэгдүүлэхэд анхаарах

Өөрийн үнэлгээний тайланд:

- ✓ Оюутан элсүүлэх сургуулийн захирлын тушаал
- ✓ Тухайн мэргэжлээр 2014 оноос хойш элссэн оюутны тоо
- ✓ Элсэгчдийн ЭЕШ оноог 2015 оноос графикаар гаргасан.
- ✓ Шинээр элссэн оюутантай ажиллах мэдээллээр хангасан байдал
- ✓ Оюутны журам, Багш мэргэжлийн удиртгал хичээлийн талаарх мэдээлэл
- ✓ Мэргэжил сурталчлах ажил зохион байгуулах чиглэлүүд

1. Элсэлтийн бодлого, дүрэм журам баримталдаг байдал: Оюутан элсүүлэхдээ БШУсайдын 2013 оны А/79 тоот тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам”-д үндэслэн жил бүр МУБИС-н захирлын тушаалаар оюутан элсүүлэх журам, оюутан элсүүлэх хөтөлбөрийн жагсаалтад үндэслэн мэргэжлийн нарийвчилсан чиглэл, оюутны хяналтын тоог баталж ажилладаг. Хэдийгээр хяналтын тоо баталсан ч тухайн жилд төгсөгчдийн тоо, ЭЕШ-н оноо, мөн эхний улиралд хичээл сонголттой холбоотойгоор элсэгчдийн тоо цөөн байна. Тухалбал 2019-2020 оны хичээлийн жилд 30 оюутан элсүүлэх хяналтын тоо байсан ч төгсөгч бага тул элсэлт байхгүй байна. 2020-2021 онд багш насан туршийн боловсрол мэргэжлээр хяналтын тоог 45 аар баталсан нь нотлогдсон.

2. Элсэгчдийн ЕШ-ын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцааны хувьд: 2014 оноос хойш тус мэргэжлээр элссэн оюутны ЭЕШ-н онооны дундаж оноо 480-503 ба тусгайлан хөнгөлөлт үзүүлж элсэлт хийж ирсэн. Нийт 2014 оноос хойш 2 удаагийн төгсөлт хийсэн ба эхний жил 6, дараагийн жил 17, нийт 23 оюутан төгссөн. Одоо тус мэргэжлээр 1-р дамжаанд оюутан байхгүй, 2-р дамжаанд 12 оюутан, 3-р дамжаанд 15 оюутан, 4-р дамжаанд 3 оюутан нийт 30 оюутан 1-4-р дамжаанд суралцаж байна. Харин тухайн мэргэжлээр элсэн орсон ч нийт 23 оюутан чөлөөлөгдсөн байна. Үүний шалтгааныг тодруулбал 10 оюутан бусад сургуульд шилжиж, 1 оюутан сонирхолгүй гэж гарсан байна. Өөрөөр хэлбэл нийт 2014 оноос хойш 76 оюутантай холбоотой үйл ажиллагаа явагдсан байна. Гэхдээ энэ нь анх тусгай хэрэгцээт боловсролын мэргэжилтэй хамт зохион байгуулагдаж байгаад тусгайлан салсан тул дээрх тоон үзүүлэлт гарч байна. Харин ямар нэг байдлаар тухайн мэргэжлээр хүсэлт гарган шилжин ирсэн мэдээлэл байхгүй байна.

3. Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага хүргэдэг байдал: Тус сургуулийн багш ажилтан оюутан нар мөрдөн хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичгийн номыг байгууллагын зүгээс гаргасан ба үүнд оюутны журам боловсруулж оруулсан. Тухайн сургуульд элсэн суралцах оюутан бүрд тухайн журмыг цахим байдлаар бүрэн танилцах үүрэгтэй байдаг. Мөн тус сургуульд оюутанд үйлчлэх алба байгуулагдсанаар салбар сургууль бүр оюутан хариуцсан ажилтан ажиллуулдаг. Энэ нь оюутанд бүхий л дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий албан тушаалын тодорхойлолтын дагуу ажил үүрэг гүйцэтгэн ажилладаг байна. Энэ албан тушаалын тодорхойлолтыг захирлын 2015 оны А/12 тоот тушаалаар батлан мөрдүүлж байна. Энэ ажилтны үндсэн чиг үүрэг нь бүртгэл зохион байгуулалт, оюутны суралцахуйг дэмжих ажил, оюутны хөгжил төлөвшилд дэмжлэг үзүүлэх, төсөл хөтөлбөр, хөдөлмөр эрхлэлтийг хариуцсан ажиллах үүрэг хүлээж байна. Энэ бол тухайн сургуулийн давуу тал юм.

4. Гадаад оюутны элсэлтийн тоог нэмэгдүүлэхэд анхаарсан байдал: Багш, насан туршийн боловсрол мэргэжлээр 2014 оноос хойш элсэгчдийн дунд гадаад оюутан байхгүй.

Анхаарах асуудал:

1. Элсэлтийн тоог нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай.

5.2 Зөвлөн туслах үйлчилгээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
5.2.	Зөвлөн туслах үйлчилгээ Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.	-Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан -Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал -Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ. -Эрдэм шинжилгээ судалгааны ажлын тайлан мэдээ	- Хөтөлбөрийн албанд оюутан хариуцсан ажилтны ажлын байр гаргаж оюутанд зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байна. Зөвлөх үйлчилгээ үзүүлдэг ажилтны ажлын чиглэлийг тодорхойлсон. Багш бүр зөвлөх багшаар оюутантай ажилласан тоо болон ажлын чиг үүргийг гаргасан. - Оюутанд үзүүлдэг 2 чиглэл /хувь хүний болон, мэргэжлийн /-ээр хийдэг ажлыг тайлбарлан бичсэн.	• Зөвлөх үйлчилгээний талаар хийсэн ажилд дүн шинжилгээ хийх дутмаг

Өөрийн үнэлгээний тайланд:

- ✓ Сургуулийн оюутанд үйлчлэх төвийн үйл ажиллагааны төрөл, чиг үүрэг
- ✓ Оюутанд үйлчлэх ажлын / сургалт судалгааны ажил гүйцэтгэх, мэдлэг мэдээллийг амьдралд хэрэгжүүлэх, туршлага хуримтлуулах, урамшуулах, хөгжлийг дэмжих / ажлыг оюутны журамд тусгайлан зааж өгсөн
- ✓ 2019-2024 онд хэрэгжүүлэх оюутны хөгжлийн хөтөлбөр боловсруулсан
- ✓ Оюутанд үзүүлдэг хөнгөлөлт, тэтгэмж урамшууллын төрлийг гаргасан.
- ✓ Оюутанд үйлчилдэг албан тушаалтан- зөвлөх багш, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, оюутанд үйлчлэх ажилтан, сэтгэл зүйч, эмч нарын ажлын чиг үүргийг тодорхойлсон.
- ✓ Тэнхимийн багш нар оюутанд зөвлөх багшаар ажилласан оюутны тоо
- ✓ Оюутныг дэмжих хувь хүний хөгжил, мэргэжлийн хөгжил дэмжих олон талт ажлын талаарх клубийн үйл ажиллагааг тодорхой гаргасан.
- ✓ Оюутан бүрд жил бүр зохион байгуулдаг ажлыг гаргасан байна.

1. **Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө гаргаж ажилласан байдал:** Тус сургуулийн хүрээнд оюутанд үйлчлэх алба байгуулан сургууль бүр дээр тодорхой ажлын байр гаргаж тухайн ажилтны албан тушаалын тодорхойлолтоор ажил үүргийг тодорхой болгож өгсөн нь ололттой тал юм. Энэ үйлчилгээг оюутан нартай уулзах уулзалтаар тодруулан асуухад нэр зааж тэр хүн сайн ажиллаж байсан энэ хүн ингэж ажилласан гэсэн үнэлгээ өгч байгааг хархад оюутанд үйлчлэх ажилтан нь оюутанд чухал хэрэгцээ шаардлагатай хүний нэг байна. Мөн тэнхимийн багш нар оюутны тоо цөөн учир оюутанд зөвлөн туслах үйлчилгээг сайн үзүүлж байгааг оюутны ярилцлагаас тодруулсан болно. Багш бүр оюутанд зөвлөн туслах ажилдаа мэргэжлийн хөгжлийг дэмжих олон талт ажлыг зохион байгуулдаг. Оюутанд зөвлөн туслах ажлын төлөвлөгөө нь оюутны зөвлөлөөс сургуулийн хэмжээнд жил бүр тогтмол зохион байгуулдаг ажил, тухайн салбар сургуулийн хүрээнд оюутанд үйлчлэх ажилтны зүгээс хамтарч боловсруулан багш бүрээр тодорхой ажлыг жил бүр төлөвлөн тайланг

гаргаж ажилласан байна.Ажлын төлөвлөгөө болон тайланг эрдэм шинжилгээ судалгааны ажлын чадвар төлөвшүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжих зөвлөн туслах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, зөвлөгөө үйлчилгээ, нийгмийн идэвх оролцоог дэмжих, чиглэлээр төлөвлөж тоо баримтаар үр дүнг тооцон гаргасан байна. Оюутанд үзүүлж байгаа хувь хүний чадвар төлөвлөвшүүлэх ажилд амьдрах ухааны сургалт чухал байгааг төгсөгч оюутан нартай уулзах уулзалтаас харагдаж байсан.

2. **Сэтгэл ханамжийн судалгаа хийдэг байдал:** Оюутны хөгжлийг дэмжих үйл ажиллагаа нь оюутнаас гарсан санал өнгөрсөн жил зохион байгуулсан ажлын үр дүн зэргээс хамаарч оюутанд үйлчлэх ажилтан сургуулийн нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулан жил бүр төлөвлөгөө зохион байгуулж хэрэгжүүлдэг байна. Төлөвлөлтөд тусгасан ажлуудаас биелэлтийг тооцон хархад бүгд сайн биелэлттэй үр дүнтэй зохион байгуулсан байна. Иймд оюутны хөгжлийг дэмжих үйл ажиллагаа нь оюутны санал хүсэлтэд үндэслэн зохион байгуулдаг тул оюутны сэтгэл ханамж өндөр биелэлт сайн байгаа нь тайлангаас тодорхой харагдаж байна. Боловсрол судлалын сургуулийн хэмжээнд ангийн дарга нарын групп дээр санал сэтгэгдэл өндөр харагдаж байна. Энэ бол тус тэнхимийн оюутны тоо цөөн байгаа нь давуу тал болж багш бүр оюутан бүртэй хамтарч ажиллах боломж юм.
3. **Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ:** Жил бүр оюутны дунд хувь хүний хөгжил, мэргэжлийн хөгжлийг дэмжих хүрээнд олон ажил зохион байгуулагдсанаас тогтмол хийгддэг ажил нь тэнхимийн зөвлөх багш нар /нийт 5/ оюутныг тэтгэлэгт хөтөлбөрт тодорхойлсон, оюутныг хөгжүүлэх сургалт үйл ажиллагаанд /нийт 25/ оюутныг нэр дэвшүүлж сургалтад хамруулж, оюутны хөгжлийг урамшуулах ажил хийгдэж байна. МУБИС-ийн оюутны “Багшлахуйн ур чадварын олимпиад” жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг. Энэ олимпиадад 2 жил, 2 удаа оролцож, эхний жилийн төгсөгч 5 оюутан оролцож 3-р байр эзэлсэн амжилт үзүүлсэн амжилт гаргасан.
4. **Эрдэм шинжилгээ судалгааны ажлууд:** Оюутнуудын мэргэжлийн хөгжлийг дэмжих чухал ажлын нэг бол Эрдэм шинжилгээ судалгааны ажил юм.Үүнд: 2019-2020 оны хичээлийн жилээр хархад 2019 оноос эхлэн тэнхимээс уламжлал болгон зохион байгуулдаг “Оюутны эрдэм шинжилгээний бага хурал”-д оролцсон нийт 11 багийн 25 оюутныг хамруулан зохион байгуулж урамшуулсан. Оролцсон бүх оюутнуудад 5000 – 10000 төгрөгийн нийт 90,000 төгрөг, өргөмжлөлийн хамт урамшуулсан. “Монгол, оросын боловсрол, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, асуудал” олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд 4 оюутан хамтарсан илтгэл хэлэлцүүлж 3-р байранд шалгарсан амжилт үзүүлсэн. “Багшийн мэргэжлийн практикт тулгамдаж буй асуудал, шийдэл” оюутны эрдэм шинжилгээний бага хуралд оюутан 3 оюутан хамтарч илтгэл хэлэлцүүлсэн. ЭШХ-д оюутныг оролцуулах, мэргэжлийн хөгжлийн чиглэлээр нээлттэй уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, хувь хүний хөгжилд тулгуурлан мэргэжлийн хөгжлийг дэмжих олон ажил зохион байгуулж байна.

Анхаарах асуудал:

1. Оюутанд зөвлөх үйлчилгээ үзүүлдэг ажилтны ажлыг үн дүнтэй болгоход анхаарах

5.3.Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт Давуу тал
5.3.	Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.	- Оюутны клубийн зохион байгуулсан арга хэмжээ, тайлан мэдээ -Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал -Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл. -Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчийн тоо, үр дүнгийн мэдээлэл -Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо	-Оюутны тэтгэлэгт хамрагдах чиглэл / боловсролын зээлийн сан, үндэсний тэтгэлэг, хэмжээ/зээл тусламж авсан оюутны тоог сүүлийн 5 жилээр гаргасан. - Оюутанд үйлчлэх алба, сайн дурын ажил, клубийн үйл ажиллагааг дэлгэрэнгүй тусгай өгсөн. Оюутны дунд зохион байгуулагддаг ажлыг тодорхой тусгасан.

Өөрийн үнэлгээний тайланд:

- ✓ Жил бүр оюутны сургалтын үйл ажиллагааны нэгдсэн хуваарьт тусгасан ажлын чиглэл
- ✓ Сайн дурын клубийн үйл ажиллагаа
- ✓ Олимпиад уралдаан тэмцээнд оролцсон оролцоо
- ✓ Оюутанд үзүүлсэн тэтгэлэг, хөнгөлөлтийг ангилан тусгасан байна.

1. **Оюутны клубийн зохион байгуулсан арга хэмжээ:** Тус сургуулийн оюутан бүр сайн дураараа оюутны клубд нэгдэх, үйл ажиллагаанд оролцох боломж нээлттэй бөгөөд идэвх зүтгэлтэй ажилласан оюутны оролцоог оюутны хөгжлийн албаны тодорхойлсны дагуу 1 кредитийн хөнгөлөлтийн урамшуулал 1 удаа үзүүлнэ. Тэнхимээс “Оюутны танилцах өдөрлөг”-г уламжлал болгон зохион байгуулж, өөрийн мэргэжлийг танилцуулах, ахлах курсийн оюутнуудтай танилцах, их сургуулийн соёл, сурах арга барилыг мэдэж ойлгох, бие даан ажиллаж амьдрахад нь туслалцаа үзүүлж мэргэжлийн бүх багш хамтран нэг өдрийг өнгөрүүлдэг.
2. **Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшууллын байдал:** “Олон нийтийн боловсрол”, “Албан бус боловсролын онол арга зүй” хичээлийн бие даалтын ажлын хүрээнд 4-5 оюутан 1 баг болгон 3 жилийн хугацаанд 20-25 удаагийн олон нийтийн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Боловсролын чиглэлээр ТББ-ын Үндэсний хэмжээний хэлэлцүүлэг, олон нийтийн гүйлтийн арга хэмжээнд 3 удаагийн нийт 48 оюутны сайн дурын ажилтнаар оролцсон.
3. **Цагийн ажил, үндсэн ажилд зуучилдаг байдал:** Ажиглах дадлага, судлах дадлага, туршин заах дадлагыг оюутан улирлын турш байгууллага дээр хийдэг нь дадлага удирдаж буй багшийн удирдлага, зохион байгуулалт, дадлагыг хүлээн авсан байгууллагын хамтын ажиллагааны үр дүнд тухайн суралцагчийн ур чадвар, мэргэшсэн байдал нь танигдаж, улмаар дадлага хийх хугацаандаа ажлын байртай

болох үндэс тавигдаж байна. Ийнхүү дадлага хийлгэж буй байгууллага ба манай тэнхимийн хамтын ажиллагааны түншлэлийн үр дүнд 2019 оны төгсөгчдөөс 3 нь, 2020 оны 6 нь оюутан *байхдаа ажлын урилга авсан*.

4. **Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчийн байдал:** Шинэ гарсан мэргэжил тул оюутнууд мэргэжлийн чиглэлээр олимпиад уралдаан тэмцээнд оролцсон оролцоо бага харин спортын төрлөөр уралдаан тэмцээнд амжилттай оролцож ирсэн нь хувийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа юм. 2019-2020 оны хичээлийн жилийн төлөвлөсөн ажлаас сургуулийн хэмжээнд гар бөмбөгийн тэмцээнд 140 оюутан, урлагын наадамд 58 оюутан, бүтээлийн үзэсгэлэнд 3 удаа, тус тус 120 оюутан оролцсон байна
5. **Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо:** Оюутанд үзүүлсэн тэтгэлэг үйлчилгээ нь: 2015 оноос хойш оюутны хөгжлийн зээлд тус тэнхимээс 2018 онд 6 оюутанд 11%, 2019 онд 11 оюутан 13%, нийт давхардсан тоогоор 17 оюутан, буцалтгүй тусламж үзүүлэхэд 2016 онд 6 оюутанд 12,7%, 2017 онд 5 оюутанд 9,6%, 2018 онд 7 оюутан 12,5%, 2019 онд 12 оюутан 12%, нийт давхардсан тоогоор 30 оюутан, замын зардал 2016 онд 13 оюутан 12%, 2017 онд 7 оюутан 7,4%, 2018 онд 9 оюутан 8,1%, 2019 онд 11 оюутан 6,5% нийт давхардсан тоогоор 40 оюутан тус тус хамрагдсан байна. Оюутны тэтгэлэг хөнгөлөлтөд тус тэнхимийн бүх оюутан 100% бүрэн хамрагдаж байна.

5.4 Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
5.4.	Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.	-Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа -Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа, дүрэм журам	-Оюутны шилжилт хөдөлгөөнийг зохицуулдаг алхамчлалыг тодорхой гаргасан. -Кредит дүйцүүлэн тооцох журмаар зохицуулалт хийх мэдээллийг гаргаж шилжилт хөдөлгөөний талаар тодруулж ажилладаг.	Оюутны шилжилт хөдөлгөөнийг багасгахад анхаарах

Өөрийн үнэлгээний тайланд:

- ✓ Оюутны шилжилт хөдөлгөөн зохицуулах дүрэм журам / Оюутны журамд тусгасан/
- ✓ Оюутны шилжилт хөдөлгөөн хийх алхамчлалыг тодорхой тусгасан
- ✓ Кредит дүйцүүлэн тооцох зохицуулалтын журам
- ✓ Шилжсэн гарсан оюутны тоон мэдээлэл
- ✓ Тэнхимийн оюутны чөлөө авсан оюутны тоон мэдээлэл
- ✓ Тус тэнхимд суралцаж байгаа оюутны тоон мэдээллийг оруулан тайлбарласан байна.

1. 2014 оноос багш насан туршийн боловсрол мэргэжлээр 2 удаагийн төгсөлт хийсэн ба эхний жил 6, дараагийн жил 17, нийт 23 оюутан төгссөн. Одоо тус мэргэжлээр 1-4

дүгээр курсэд нийт 30 оюутан суралцаж байна. Харин тухайн мэргэжлээр элсэн орсон ч нийт 23 оюутан чөлөөлөгдсөн байна. Үүний шалтгааныг тодруулбал 10 оюутан бусад сургуульд шилжиж, 1 оюутан сонирхолгүй гэж гарсан байна. Мөн одоо суралцаж байгаа нийт 30 оюутан дээр нийт 22 оюутан хагас болон жилийн чөлөө авсан чөлөөтэй байна. Эдгээр оюутны шалтгааныг тодруулбал эрүүл мэндийн шалтгаанаар 5, жирэмсний амралт авсан 3, ар гэрийн шалтгаанаар 12, цэргийн албанд 1, гадаадад 1 оюутан суралцаж байна. Иймд дээрх тоон мэдээллийг нэгтгэвэл нийт тус тэнхим байгуулагдсан 2014 оноос хойш 6 жилийн хугацаанд 98 оюутантай үйл ажиллагаа явуулсан байна. Энэ талаар өөрийн үнэлгээний тайланд сургуулиас гарсан хүүхдийн тоо, чөлөө авсан оюутны тоо, одоо суралцаж байгаа хүүхдийн тоо тус бүрийг хүснэгтлэн тооцоолж гаргасан.

- Кредит дүйцүүлэн тооцох шууд шалгалтаар тооцох зохицуулалт нь тус сургуулийн оюутны журмын 4,3,2 -т сургалтын журмын 4,12 –т тус тус зааснаас оюутан хөтөлбөрийн албаны даргад хүсэлт гаргаж шууд шалгалт өгч кредит тооцуулах зохицуулалт хийсэн байна.

Анхаарах асуудал:

- Оюутны шилжилт хөдөлгөөнийг багасгах талаар нөлөөллийн ажилд анхаарах

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт
5.5.	Төгсөлтийн баримт бичиг Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь гүйцэтгэл, хөтөлбөрийн үр эзэмшсэн түвшин тусгасан байна.	-Төгсөлтийн баримт бичгийн загвар -Төгсөлтийн баримт бичгийг олгох хэрэгжилтийн байдал	-Төгсөлтийн баримт бичгийн загвартай Төгсөлтийн ажлын алхамчлал, шалгалтын талаар журмын дагуу явуулдаг.

Өөрийн үнэлгээний тайланд:

- ✓ МУБИС-н сургалтын журамд заасан /мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрийн заавал болон сонгон судлах хичээлүүдийг амжилттай судалж 120 –оос доошгүй кредит цуглуулсан, ахицын шалгалтаар хангалттай үнэлгээ авсан дүрэм журам шаардлага биелүүлсэн 1,7-с доошгүй голч оноотой суралцагчид МУБИС-ийн бакалаврын зэрэг олгоно/
 - ✓ Төгсөлтийн баримт бичиг дипломын загвар, хавсралтын загварыг өнгөтөөр хавсаргасан.
 - ✓ Төгсөлтийн баримт бичиг олгох үйл ажиллагаанд тавих хяналтын талаарх мэдээлэл
- Багш, Насан туршийн боловсролын чиглэлээр төгсөгчдөд МУБИС-н удирдах зөвлөлийн дарга, МУБИС-ийн захирал, төгсөлтийн ерөнхий комиссын дарга,

сургалт эрхэлсэн дэд захирал, бүрэлдэхүүний сургуулийн захирлын гарын үсэг, бүртгэлийн дугаартай байна. Дипломын хавсралтад эзэмшсэн болон хавсарга мэргэшил, суралцах хугацаанд судалсан хичээл, кредит, дипломын ажлын сэдэв, улсын шалгалтын дүн голч дүн, оноог бичихээс гадна эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрт нийцүүлэн бусад бичиглэл хийхээр тайлбарласан байна. Дипломын хавсралт дээр хөтөлбөрийн нэгдсэн алба болон бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн албаны даргын гарын үсэг тэмдэгтээр баталгаажуулж дипломын хамт хүчинтэй байхаар тогтоосон байна.

2. МУБИС-н нэг онцлог нь D код нь багшлах эрхтэй дипломын хавсралтад байх шаардлага бүхий онцлогтой.
 - Диплом олгох үйл ажиллагаа нь Монгол улсын БСШУС-ын яамны шийдвэр, дүрэм журам ба хуулийн хүрээнд явагдах үйл ажиллагаа болно. Дипломын дүнгийн голч нь 3.7 ба түүнээс дээш тохиолдолд магистрын сургалтад шалгалтгүй элсэх боломжтой бөгөөд төлбөрөөс 15% хөнгөлөлт үзүүлдэг байна. Багш насан туршийн боловсролын чиглэлээр шалгалт нь 2 хувилбартай зохион байгуулагдана. Үүнд: Багш насан туршийн боловсрол /тест, бүтээлч даалгавар-70%/, Боловсрол судлал /тест-30%/, Дипломын ажил /Судалгааны ажил 70%/, Боловсрол судлал /тест 30%/
3. 2019 оны байдлаар тус мэргэжлээр төгссөн 23 оюутнаас 8 оюутан дипломын ажил хийсэн байна. Багш насан туршийн боловсролын чиглэлээр 8 магистр суралцаж, 5 докторын зэрэг хамгаалсан байна.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ШАЛГУУР 6. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1 Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого

Шалгуурыг хангасан байдал : Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт
6.1.	Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага	-Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлантай. Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин 42.8. -Багш суралцагчдын тооны зохистой харьцаатай. Нэг багшид 10 оюутан. -Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцэж ажилладаг. -Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа, Багш нарт олгосон урамшууллын системтэй.	- Тус тэнхимд 3 доктор, магистр 4 нийт 7 үндсэн багштай бөгөөд энэ нь 42,8 % нь докторын зэрэгтэй . - Хүний нөөцийн цогц бодлогын талаар сургуулийн багш сонгон шалгаруулж авах журам, үе шат, нөөцөд байгаа сургуулийн ахмад багш нартай гэрээ байгуулж ажилладаг. - Багшийн албан тушаалд тавигдах шаардлага, мэргэжлийн хичээл заадаг чиглэлээр багш нарын судалгаатай.

бүхий нөөцтэй байна.	багшийн
-------------------------	---------

Ололттой тал:

1. Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн хувьд:

МУБИС-ийн журмын дагуу шаардлага хангасан багш нь дадлагажигч багш, багш, ахлах багш, дэд профессор, профессор гэсэн тохирох зэрэглэлд ажиллуулдаг ба үүнийг захирлын зөвлөлөөр шийдвэрлэнэ. Одоо тус тэнхимд хими биологийн чиглэлээр мэргэшсэн 3 багш, мэдээллийн технологийн мэргэжилтэй 3 багш, физик математикийн мэргэжилтэй 1 багш ажиллаж байна. Шинээр багш ажиллуулах нь тухайн тэнхимийн багшийн цагийн ногдол ачаалал, гурван жилийн төгсөлтийг харгалзан үзэж багш авах үндэслэлээ сургуулийн удирдлагад гаргадаг тул одоогийн байдлаар тус тэнхимийн багш нарын хүний нөөцийн бодлого бүрэн тодорхой болоогүй байна.

2. Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувь:

Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд тус тэнхимийн багш нарын хувьд 6 үндсэн багштай 1 зөвлөх багш ажилладаг. Багш нараас 3 доктор, магистр 4 /докторант/ байгаа нь 42.8% нь юм. Багш нартай уулзах уулзалтаар 2021 онд бүх багш нар докторын зэрэг хамгаалах хувийн хөгжлийн төлөвлөгөө гарган ажиллаж байгааг тэнхимийн зөвлөх багш С.Эрдэнэцэцэг багш танилцуулсан. Тэнхимийн ахмад багш залуу багш нарын халамжлан хүмүүжүүлэх зөвлөн туслах, судалгааны чиглэлээр сайн зөвлөдөг. Багш нарын хувьд залуу боловсон хүчинтэй үүний зэрэгцээ салбар сургуулийн зүгээс багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжин ажилладаг талаар тухайн багш нартай хийсэн уулзалтаас харагдсан. /Сургуулийн багш нар өөрийн сургуульдаа докторантад суралцах тохиолдолд төлбөр 50% хөнгөлөгддөг/

3. Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцдэг байдал:

МУБИС-иас эрхлэн гаргасан Бодлогын баримт бичгийн “Багш сонгон шалгаруулах журам”-ын 3.3.1-т “Албан тушаалын зэрэглэл тогтоох” зэрэг журмаар зохицуулдаг. Багш насан туршийн боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлдэг тэнхимийн үндсэн болон гэрээт багш нараас удирдах ажилтан 1/ тэнхимийн эрхлэгч/, зөвлөх профессор, профессор 2, үндсэн багш 4, гэрээт багш 7, цагийн багш 1 ажиллаж байна. Эдгээр багш нар сургуулийн бодлогын баримт бичигт тусгасан “Албан тушаалын зэрэглэл тогтоох” журмын дагуу шалгуур шаардлага ханган ажиллаж байна.

4. Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа,

МУБИС-ийн багш суралцагчдын харьцаа 21 нэг бол Багш, насан туршийн боловсрол, зайн сургалтын тэнхимийн харьцаа багш суралцагчдын харьцаа 64:6 /10 гэсэн тоо үзүүлэлт өөрийн үнэлгээний тайланд гаргасан байна. Тус тэнхимд ажиллах багшийн тоог тооцож гаргахдаа сургуулийн эрх зүйн баримт бичигт тухайн мэргэжлээр 3 жил элсэлт, төгсөлт хийсний дараа сургуулийн захиргаанд багшийн ачаалал тооцсон санал гаргахаар тусгасан байна. Энэ мэргэжил нь 2020 онд 3 дахь төгсөлтөө хийхээр төлөвлөгдсөн тул багш нарын ачаалал нь зөвхөн тоон үзүүлэлтээр гарсан байна.

5. Багш нарт олгосон урамшууллын байдал:

Багш, насан туршийн боловсрол зайн сургалтын тэнхимээс багш нараа мэргэжил дээшлүүлэхэд анхаарч төлбөрийн 50% урамшуулал олгох, дотуур байранд байрлах тохиолдолд 50% хөнгөлөлт үзүүлэх, мэргэжлийн дагуу ном гарын авлага хэвлүүлэхэд 1 сая төгрөг хүртэлх урамшуулал дэмжлэг үзүүлэх, судалгаа шинжилгээний ажлыг бичил төслөөр 5 сая хүртэлх тэтгэмж санхүүжүүлж урамшуулах ажлыг зохион байгуулдаг. Харин МУБИС-иас эрхлэн гаргасан Бодлогын баримт бичгийн “Багш сонгон шалгаруулах журам”-ын 3.8.1-т “Урамшууллын бодлого” дэд журмаар зохицуулдаг байна. Магистр, докторын тэтгэлэгт хөтөлбөрийн тухай журамд тодорхой заасан.

Анхаарах :

1. Урамшууллын бодлогын журамд заасан хэрэгжилтийн үр дүнг тооцох санхүүгийн баримт, судалгаа байхгүй байсан.

Ололт:

1. Докторын сургалтад суралцахад төлбөрийг 50 хувь хөнгөлдөг.
2. Судалгааны ажил зохион байгуулсан багшийг бичил төслөөр дэмждэг.

6.2 Багшийн хөгжил

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
6.2.	Багшийн хөгжил Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.	-Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаатай. Багш нарыг мэргэжил дээшлүүлэхэд анхаарч ажилладаг. -Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлдэг.	-Тэнхимийн багш нар нь 4 оронд 5 хүн хамрагдсан байна. -Тэнхимийн багш нараас бусад багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр сайн ажил хийдэг.	-Тэнхимийн багш нарын хувийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө түүний биелэлт үр дүн тайланг анхаарах

1. Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон байдал:

МУБИС –ийн зүгээс багш нарын хөгжлийг дэмжихэд 2018 онд “Багш хөгжлийн төв” байгуулж багшийн хөгжлийн хөтөлбөрийг сургуулийн хэмжээнд хэрэгжүүлж байна. Багшлахуйн ур чадварыг дээшлүүлэхэд тус тэнхим нь:

- Багш мэргэжлийн хөрвөх сургалтаар “Багш боловсрол”-ын багц 23 кредит сургалтыг 2016-2017 оны хичээлийн жилээс орсон.
 - Их, дээд сургуулийн багш нарт “Багшлах мэргэжил “ хичээлийг тус тэнхим зохион байгуулж ирсэн нь багш нарын багшлахуйн ур чадвар хангалттай төвшинд хүрсэн.
 - Багшлахуйн сургалтыг зайн хэлбэрээр онлайнгаар сургалт зохион байгуулж байна.
 - Бусад байгууллага нэгжид захиалгаар судалгааны арга зүй, сурган хүмүүжүүлэх ёс зүйн сургалтыг байнга явуулж байна.
2. Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхижуулсан байдал:

Багш нартай хийсэн ярилцлагаас Багш, насан туршийн боловсролын чиглэлээр 9 хүн магистр хамгаалж, 5 хүн докторын зэрэг хамгаалж одоо 8 оюутан магистрт суралцаж байна. Тус тэнхимийн багш нар нь тэнхим байгуулагдсанаас хойш Япон, БНХАУ, АНУ, ОХУ зэрэг орнуудад мэргэжил дээшлүүлэх сургалтад давхардсан тоогоор 5 хүн хамрагдсан нь 6 багштай тэнхимийн хувьд өндөр үзүүлэлт юм. Багш нарыг дотоодын сургалт англи хэл, төслийн хүрээнд үндэсний сургагч багшийн сургалт, багшлах дадлага ажил удирдах сургалтад тэнхимийн багш нараа хамруулан дэмжлэг үзүүлсэн.

Ололт амжилт:

1. Багшийн хөгжлийн хөтөлбөртэй
2. Тэнхим хөгжүүлэх хөтөлбөртэй (2019-2021)

Анхаарах асуудал:

1. Багшийн суралцах хэрэгцээг тодорхойлсон баримт судалгаа байхгүй

6.3 Эрдэм шинжилгээ, судалгаа

Шалгуурыг хангасан байдал : Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
6.3.	Эрдэм шинжилгээ, судалгаа Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.	-Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентийн тоон судалгаа -Бодлогын баримт бичиг, дүрэм журам -Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан байдал -Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо -Зарцуулсан төсөв, тайлан	- Тэнхимийн багш нарын гадаад дотоод хэлэлцүүлсэн илтгэлийн судалгааг сүүлийн 5 жилээр гарган хавсаргасан. 4. Тэнхимээс зохион байгуулсан сургалтыг сүүлийн 5 жилээр гаргасан. -Багш нарын өөрийгөө хөгжүүлэхэд чиглэсэн сургалтад суусан тоон үзүүлэлт, өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр хийсэн ажлын тоон үзүүлэлтийг графикаар гаргасан.	- Тэнхимээс цаашид төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд анхаарах • Насан туршийн боловсролын чиглэлээр судалгаа шинжилгээний ажил зохион байгуулахад анхаарах

Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентийн тоо: Тэнхимийн багш нарыг чадваржуулахад гадаад, дотоод эрдэм шинжилгээний хуралд оролцуулах ажлыг сургууль, тэнхимээс дэмжиж ирсэн. **Дотоодод:** МУБИС, МУИС, БХ, БМДИ, БҮТ, НТБҮТ зэрэг боловсролын яамны харьяа байгууллагаас зохион байгуулж байгаа эрдэм шинжилгээний хурал, их дээд сургуулиудын дунд зохион байгуулагддаг эрдэм шинжилгээний хуралд байнга оролцож байна. **Гадаадад:** Багш нарыг урт богино хугацааны сургалтад хамруулан эрдэм шинжилгээний ажил хийх дадлага туршлагатай болгоход анхаарч ажилласан тул одоо 2021 онд тус тэнхимийн 4 багш эрдмийн зэрэг хамгаалахад бэлтгэгдэж байна. Багш Ж.Шинэбаяр нь ОХУ-д Дубна хотод цөмийн физикийн судалгааны төвд 3 сарын хугацаанд виртуал лабораторийн судалгаа хийсэн. Энэ судалгааны ажлын хүрээнд “Онлайн сургалтын арга зүй” хичээлийн

үндсэн сургалтын гарын авлага боловсруулж байна. Одоогоор тэнхимийн үйл ажиллагаа шинэ тутам байгаа тул инноваци, ашигтай загвар, патент гаргаагүй байна. Харин гадаад дотоод төсөл хөтөлбөрийн хүрээнд 5 төсөл хэрэгжүүлж байна. Патент эзэмшдэг багш одоогоор байхгүй. С.Эрдэнэцэцэг, Д.Оюунбилэг багш нарын 8 төрлийн номтой.

1. Бодлогын баримт бичиг, дүрэм журмын хэрэгжилт

МУБИС-иас эрхлэн гаргасан багш оюутанд зориулсан “Бодлогын баримт бичиг” эмхтгэл гаргасан нь тухайн байгууллагын хүрээнд дагаж мөрдөх бүхий л баримт бичиг эрх зүйн зохицуулалтыг боловсруулан гаргасан нь давуу талтай. Тэнхим 2014 онд байгуулагдсанаасаа хойш нийт гадаад дотоодын 5 төсөл хөтөлбөрт хамтран ажилласан байна.

- 2014-2015 ШУТС “Пиннингийн технологийг цөмийн технологид ашиглах нь
- 2015-2016 Монгол Японы хамтарсан “Тусгай хэрэгцээт боловсролын төсөл”
- 2016-2017 БСШУСЯ “Бага дунд бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөрт ТХБ-ын үзэл санаа агуулгыг тусгах нь” төсөл
- 2017-2018 Япон “ЕБС-н байгалийн ухааны хичээлийг МХТ ашиглан сайжруулах нь”
- 2018-2019 БСШУСЯ “Хэт авиа ба лазераар өдөөгдсөн микро болон нано кавитацын идэвхжлийг эрчимжүүлэх технологийн физик үндэслэл”

2. Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо

Багш нар нь гадаад дотоодод эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх, эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавих, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд санаачлагатай ажилладаг бөгөөд мэргэжлийн чиглэлээр нилээд сургалт явуулдаг нь энэ чиглэлээр эрэлт хэрэгцээ байгааг илэрхийлж байна. Сүүлийн 4 жилийн хугацаанд олон улсад хэвлүүлсэн өгүүлэл-9, илтгэл-13, үндэсний хэмжээнд хэвлүүлсэн өгүүлэл-13, илтгэл -4, судалгааны төсөл-4, мэргэжлийн чиглэлээр сургалтыг 38 удаа зохион байгуулсан байна.

Хүснэгт Багш нарын хэвлүүлсэн өгүүлэл, итгэлийн тоо

Он	Олон улсад		Үндэсний хэмжээнд		Судалгааны төсөл	Мэргэжлийн үйлчилгээ
	ЭШӨ	Илтгэл	ЭШӨ	илтгэл		
2016	3	5	-	2	1	4
2017	1	1	7	2	1	5
2018	3	3	6	-	2	18
	2	4	-	-	1	11
Нийт	9	13	13	4	5	38

Анхаарах асуудал:

1. Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг эрчимжүүлэхэд анхаарч ажиллах;
2. Зайны сургалтын чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, турших

6.4 БАГШИЙН ҮНЭЛГЭЭ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
6.4.	Багшийн үнэлгээ Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.	-Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх журам, хэрэгжилтийн тайлангууд. -Багш нарын жил бүрийн өөрийн үнэлгээний тайлан. -Удирдлага, оюутнуудын хөндлөнгийн үнэлгээний тайлан. -Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайлан мэдээ -Багш бүр хавтастай.	- Сургуулийн зүгээс багш нарын ажлыг үнэлдэг тодорхой журмын дагуу багш нар ажлаа үнэлүүлдэг тухай мэдээлэл оруулсан. - Багшийн ажилд оюутны сэтгэл ханамжид тулгуурласан хөндлөнгийн үнэлгээ хийж багш бүрээр гаргасан. -Багш нараас олон нийт болон нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг үнэлэх шалгуур гаргасан.	• Багшийн хавтасны талаарх мэдээлэл оруулах

1. Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам, хэрэгжилтийн тайлан

МУБИС-аас эрхлэн гаргасан багш оюутанд зориулсан “Бодлогын баримт бичиг” эмхтгэлд багшийн өөрийн үнэлгээний систем хөгжүүлэх тодорхой журам үйлчилдэг. Журмын зорилго нь багш ажилтны ажлын төлөвлөлт сайжруулах, өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх хүний нөөцийг чадваржуулахад чиглэгдсэн байна. Багшийн үнэлгээний үйл ажиллагааны алхамчлал нь:

- Жил бүрийн хавар багш нар өөрийн үнэлгээний тайлангаа цагийн гүйцэтгэл, бүтээлийн жагсаалт зэрэг төлөвлөлтийн дагуу хийсэн ажлаа сургалтын удирдлага мэдээллийн системд түшиглэн гаргадаг.
- Сургуулийн удирдлага, тэнхимийн эрхлэгч багш нарын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнгийн нэмэгдлийг улирал тутамд олгодог.
- Багш нарын өөрийн үнэлгээнд үнэлэлт өгч ажилладаг уламжлал тогтсон.

2. Хөндлөнгийн үнэлгээний дүн

Багш нарын ажлын гүйцэтгэлд хийх хөндлөнгийн үнэлгээг улирал тутам оюутнаас авч шалгалтын дараа танилцуулах журам тогтсон байна. Энэ үнэлгээгээр тус тэнхимийн багш нар 2014 оноос хойш 80-99% тай үнэлэгдсэн байна. Байгууллагын зүгээс удирдлага 2 жилд 1 удаа профессор, багш нарыг аттестатчилдаг. Энэ нь тухайн багш ажилтанг 100 хүртэлх оноогоор үнэлж ажлыг сайжруулахад дүгнэлт өгч ажиллахад чиглэсэн байна. Түүнчлэн 2 жилд 1 удаа чанарын баталгаажуулалт мониторингийн албанаас багш нарын ахиц дэвшилд үнэлгээ хийж, /сургалтын үйл ажиллагаа, эрдэм шинжилгээ судалгаа шинжилгээний ажил, олон нийтийн үйлчилгээ/ өндөр үнэлгээ авсан багш ажилтанг урамшуулах, албан тушаал ахиулах болон шагнаж урамшуулдаг. Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш бүр жилд 1 удаа нээлттэй хичээл зохион байгуулдаг. Багш нарыг олон нийтэд нээлттэй байдлаар ажиллуулахад тодорхой кредитийг тооцон ажиллах талаар өөрийн үнэлгээний тайланд дэлгэрэнгүй хавсаргасан байна.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ШАЛГУУР 7. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

7.1. ХӨТӨЛБӨРИЙН ЧАНАРЫН ДОТООД БАТАЛГААЖУУЛАЛТ, САЙЖРУУЛАЛТ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт
7.1.	Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.	-Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схемтэй. -Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийдэг. -Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр анхаарч ажилладаг.	- Сургуулийн хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын тогтолцоог харуулсан мэдээлэл, бодлого журмын танилцуулгатай. - Багш хичээлийн стандарт хөтөлбөрөө баталгаажуулах үе шатыг гаргасан. - Сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэх, үе шат үнэлгээний хэлбэр, баталгаажуулах төлөвлөгөөний загвар гаргасан. Чанарын баталгаажуулалтад оролцогч талуудын үүрэг оролцоог тусгасан.

Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын талаар; Удирдлага зохион байгуулалтын схем: МУБИС-ийн Хөтөлбөрийн хороо-Боловсрол судлалын сургуулийн хөтөлбөрийн хороо-Насан туршийн боловсрол, зайн сургалтын тэнхим- Сургалт эрдэм шинжилгээний зөвлөл гэсэн шатлалаар ажилладаг. МУБИС-аас 2014 онд “Чанарын баталгаажуулалт, мониторингийн алба” 2017 онд “Хяналт үнэлгээний алба” тус тус байгуулагдан ажиллаж байна. Эдгээр албаны зорилго чиг үүрэг нь хууль дүрэм журам стандарт хэрэгжилт, түүний үр дүнг шинжлэх, цаашид авах арга хэмжээг тодорхойлдог. Тус чиг үүргийн хүрээнд 6 үндсэн шалгуур үзүүлэлтээр 2 хэлбэрээр мониторинг хийж байна. Үндсэн 6 чиглэлийн нэг нь Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт юм. Өөрийн үнэлгээний тайланд хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын тогтолцоог тодорхой схемчлэн оруулсан.

Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал: МУБИС-ийн захирлын 2018 оны А/152 тоот тушаалаар “Сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэх журам” баталж хөтөлбөрийн чанар хэр бодитой эсэхэд үнэлгээ дүгнэлт өгч ажилласан. Үйл ажиллагаа нь:

- Чанарын баталгаажуулалт, мониторингийн алба, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар хөндлөнгийн үнэлгээ авч үр дүнг тооцон холбогдох алба хэлтэст хүргүүлдэг.
- Багш тухайн хөтөлбөрөөр заах хичээлийн хөтөлбөрөө хөтөлбөрийн нэгдсэн хороогоор баталгаажуулж байна.

Хөтөлбөрийн чанарыг хөтөлбөрийн хэрэгжилт, хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилт гэсэн хэсгээр 9 чиглэлээр үнэлэх шалгуур хугацааг өөрийн үнэлгээний тайланд гаргаж өгсөн.

Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн байдал: Багш насан туршийн боловсролын хөтөлбөр хэрэгжилтэд оролцогч талуудыг санал тусган сайжруулж ирсэн.

- 2016 онд нийслэлийн 7 дүүргийн НТБ-н төвүүдийн багш нартай хэлэлцүүлэг хийж хамтран ажилласан.

- 2018 онд 6 дүүргийн насан туршийн боловсролын төвийн захирлуудтай уулзалт зохион байгуулсан.
- 2019 оны 03 сард 10 аймгийн НТБ-н төвийн багш ажилтантай онлайн уулзалт хийж зохион байгуулсан. Ийм байдлаар хөтөлбөрөө 3 удаа сайжруулалт хийгээд байна. Өөрийн үнэлгээний тайланд хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалт хийх оролцогч талуудыг схемчлэн гаргаж өгсөн давуу талтай.

Анхаарах асуудал:

1. Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг харуулсан баримтыг тодорхой болгох

7.2. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт	
			Давуу тал	Сул тал
7.2.	Хөтөлбөрийн үр дүн Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.	-Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн -Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн -Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ -Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээ /Ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгч гэх мэт/ -Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа	- Төгсөгчдийн ажил ажил эрхлэлтийг тодорхой оруулж өгсөн. - Төгсөгчдийг дадлага ажлын үеэр ажлын байртай болгох талаар НТБТ-үүдтэй хамтран ажилласан. - Төгсөгчид ажлын байраар хангагдаж байгаа судалгааг гаргасан. -Хөтөлбөрийн үр дүнгийн судалгааг төгсөгчдийн дүнгийн голчийн үзүүлэлтээр гаргасан.	- Тухайн мэргэжлээр ажлын байранд ажиллаж байгаа багш нарыг мэргэшүүлэх тал дээр анхаарах - Хөтөлбөрийн үр дүнг тодорхойлох шалгуур үзүүлэлт КРІ тодорхой биш байгааг анхаарах

1. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн

Хөтөлбөрийн хэрэгжилт төгсөгчдийн ажлын байртай шууд хамааралтай. Нийт 23 төгсөгчөөс 17 нь ажил эрхэлдэг. Нийт төгсөгчийн 73.2 хувь нь ажлын байраар хангагдсан. Төгсөгчдийг ажлын байраар хангахад сургалтын үед хийгддэг 6 дадлага чухал үүрэгтэй бөгөөд ихэнх оюутан дадлага хийж байгаа газраа ажлын байраар хангагдсан байна. Төгсөгчдийн дундаж голч дүн 2.6 байна.

2. Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ

Багш насан туршийн боловсролын чиглэлээр төгсөгч нар нь ажлын байраар бүрэн хангагдах боломжтой талаар тэнхимийн зүгээс одоогийн нийслэлийн дүүрэг, орон нутаг ажиллаж байгаа багш насан туршийн боловсролын төвүүдээр судалгаа хийсэн нь үр дүнтэй ажлын нэг хэсэг юм. Тухайн мэргэжлээр үндэсний хэмжээнд 23 төгсөгч төгссөн бөгөөд одоогоор энэ мэргэжлээр багш мэргэжилтэй хүн л ажиллаж байна. Иймд төгсөгчдийн ажлын байрны судалгаа үр дүнтэй болох нь нотлогдсон.

3. Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээ /Ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгч гэх мэт/

Анхны хөтөлбөр боловсруулахад насан туршийн боловсролд ажиллагсад болон нийслэлийн дүүргүүдээс судалгаа авсан. Дараа нь дахин асуумж авснаар хөтөлбөрөө сайжруулах шаардлага гарч эхний удаад Дүрслэх урлаг заах арга зүй, Иргэний боловсрол заах арга зүй хичээлийг нэмж оруулсан байна. Жил бүрийн хичээлийн жилийн эцэст хөтөлбөрийн талаар оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авдаг.

Ажил олгогч нартай хийсэн уулзалтаар төгсөгч нарын мэдлэг харилцан адилгүй байна. Энэ нь тухайн хүүхдийн аль нэг талаараа мэргэшсэн байхаас хамаарч байна. Ажил олгогч нараас хэрэгцээ шаардлагатай чадваруудын талаар асуулга авахад багш насан туршийн боловсролын агуулгыг нэрлэж байсан нь хөтөлбөр хэрэгцээтэй агуулгаа орж байна гэж харагдсан. Үүнд: Дүйцсэн хөтөлбөрийн арга зүй, амьдрах ухааны чадвар олгох арга зүй, холимог бүлэгтэй ажиллах арга зүй, насанд хүрэгчидтэй ажиллах арга зүй зэрэг хөтөлбөрүүдийг нэрлэж байна. Харин төгсөгч нар нь бага ангийн багш мэргэжилтэй багш байгаад дараа нь энэ чиглэлээр мэргэших нь илүү тохиромжтой байгаа талаар ажил олгогч нараас гарсан санал сонирхол татаж байлаа. Тухайн мэргэжлээр төгссөн төгсөгч нартай хийсэн уулзалтаар ажлын байранд очоод ямар чадвар дутагдаж байгааг тодруулахад ярианы чадвар буюу амьдрах ухааны чадваруудыг сайн эзэмших мөн тусгай хэрэгцээт боловсрол шаардсан хүүхэдтэй ажиллах чадвар дутмаг байна мөн насан туршийн боловсролын багш гэсэн ойлголтын талаар ажил олгогч нар ойлголтогүй байгааг хэлж байсан.

4. Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа

- Хөтөлбөрийн үр дүнг хэрхэн тодорхойлсон талаар мэдээлэл дутмаг
- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа нь төгсөгчдийн ажлын байраар тооцон харвал чухал хэрэгцээтэй байгаа нь ажил олгогч нарын уулзалтаас харагдаж байна.

Анхаарах:

1. Насан туршийн боловсролын багшийн загвар гаргаж, хөтөлбөртөө тусгах
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйг хөтөлбөрт тусгах

7.3. ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨХ

Шалгуурын хангасан байдал: Бүрэн хангасан

№	Шалгуур шаардлага	Нотлох баримт	Өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт
7.3.	Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.	-Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрснийг нотлох ажил олгогчийн уулзалтын хурлын тэмдэглэл, шийдвэр -Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан баримтуудтай танилцав.	-Хөтөлбөрөөр төгсөгчдийн талаар ажил олгогчидтой хийсэн хэлэлцүүлгийн тайлангаас харахад төгсөгчид нь эрэлт хэрэгцээтэй болох нь нотлогдсон. -Насан туршийн боловсролын төвүүд болон бусад ЕБС, зэрэг мэргэжлийн байгууллага, хамт олонтой хамтран ажилладаг.

- МУБИС нь хөтөлбөрийн хяналт үнэлгээг хариуцсан мэргэжилтэн, шинжилгээний алба ажиллаж иржээ. Үүнд 2001 оноос эхлэн шинжилгээ үнэлгээний алба, 2006 оноос эхлэн эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирлын албанд үнэлгээ шинжилгээний мэргэжилтэн, 2013 оноос эхлэн дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээний төв, 2014 оноос “Чанарын баталгаажуулалт, мониторингийн алба” нэртэй тус тус зохион байгуулагдан хөтөлбөрийн дотоод хяналт үнэлгээг тасралтгүй хийж, үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ирсэн байна.
- Хөтөлбөрт чанарын үнэлгээ тогтмол хийх ажлыг эрчимжүүлэхээр хөтөлбөрийн албадаас хөтөлбөрт үнэлгээ хийх, дэд хороо байгуулан ажиллаж байна. Хөтөлбөрийн дэд хороо нь хөтөлбөрийг үнэлэх, хичээлд суух, судалгаа хийх хуудсуудыг боловсруулан хөтөлбөрийн албадаар баталгаажуулж, хөтөлбөрт үнэлгээ хийх ажлыг тогтмол зохион байгуулан ажилладаг нь хөтөлбөр өөрийн дотоод чанарын үнэлгээг хийх ажлыг тогтмолжуулсан нь харагдаж байна.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ДҮГНЭЛТ

1. ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ДҮГНЭЛТ

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Монгол улсын боловсролын их сургуулийн Боловсрол судлалын сургуулийн “Багш, насан туршийн ангийн боловсрол” сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “**ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН**” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Боловсрол судлалын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

БАГШ, НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭ

№	Шалгуур шаардлага	Шалгуур хангасан байдал
Шалгуур 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ		
1.1.	Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага	Хэсэгчлэн хангасан
1.2.	Хөтөлбөрийн зорилго	Бүрэн хангасан
1.3.	Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд	Бүрэн хангасан
Шалгуур 2. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА		
2.1.	Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл	Бүрэн хангасан
2.2.	Сургалтын арга зүй	Бүрэн хангасан
2.3.	Суралцагчийн үнэлгээ	Бүрэн хангасан
Шалгуур 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ		
3.1.	Сургалтын орчин	Бүрэн хангасан
3.2.	Сургалтын хэрэглэгдэхүүн	Бүрэн хангасан
3.3.	Сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр	Бүрэн хангасан
Шалгуур 4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ		
4.1.	Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа	Бүрэн хангасан.
4.2.	Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ	Бүрэн хангасан.
4.3.	Санхүүжилт	Бүрэн хангасан
4.4.	Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт	Бүрэн хангасан
4.5.	Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал	Хэсэгчлэн хангасан
Шалгуур 5. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА		
5.1.	Суралцагч сонгох, элсүүлэх	Бүрэн хангасан
5.2.	Зөвлөн туслах үйлчилгээ	Бүрэн хангасан
5.3.	Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо	Бүрэн хангасан
5.4.	Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн	Бүрэн хангасан
5.5.	Төгсөлтийн баримт бичиг	Бүрэн хангасан.
Шалгуур 6. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА		
6.1.	Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого	Бүрэн хангасан.
6.2.	Багшийн хөгжил	Бүрэн хангасан.
6.3.	Эрдэм шинжилгээ, судалгаа	Бүрэн хангасан.
6.4.	Багшийн үнэлгээ	Бүрэн хангасан.
Шалгуур 7. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖУУЛАЛТ		
7.1.	Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт	Бүрэн хангасан.
7.2.	Хөтөлбөрийн үр дүн	Бүрэн хангасан.
7.3.	Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх	Бүрэн хангасан.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Р.Чанцалдулам/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Р.Туяа/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Ж. Баянцэнгэл/

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийн төлөвлөлтийн хувьд төгсөгчийн ирээдүйн мэргэжлийн чиг хандлага, эзэмших мэдлэг, ур чадварт нь анхаарч STEEP, PEST зэрэг шинжилгээг хийж, дүгнэлт гарган хөтөлбөрийг тасралтгүй сайжруулдаг байх; • Хөтөлбөрийн баримт бичигт Насан туршийн боловсролын багшийн загварыг тусгах, хөтөлбөрийн агуулгад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйг тусгах;
Шалгуур 2. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	
Шалгуур 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ	<ul style="list-style-type: none"> • Сургалтын хэрэглэгдэхүүн ном сурах бичиг, гарын авлага боловсруулах ажлыг эрчимжүүлэх;
Шалгуур 4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	<ul style="list-style-type: none"> • Төгсөгчийн цогц чадамжийн гарын авлага боловсруулан багш, суралцагч, олон нийтэд сурталчлах маркетингийн сурталчилгааны ажлыг зохион байгуулан ажиллах; • Хөтөлбөрийн хороонд ажил олгогч, төгсөгчийн төлөөллийг оролцуулдаг байх; • Аймаг дүүргүүдэд ажиллаж байгаа насан туршийн боловсролын төвүүдтэй хамтын ажиллагааг идэвхжүүлэх, ЕБС-н сурагчдад мэргэжлээ сурталчлах ажлыг тодорхой түвшинд гаргахад чиглүүлэх;
Шалгуур 5. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА	<ul style="list-style-type: none"> • Оюутны шилжилт хөдөлгөөнийг багасгах талаар нөлөөллийн ажилд анхаарч ажиллах;
Шалгуур 6. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	
Шалгуур 7. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖУУЛАЛТ	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийн хувьд насанд хүрэгчдэд хичээл заах багш нарыг бэлтгэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт их байгаа тул хөтөлбөрийн хувьд 2.5 жилээр, бакалаврын анги төгссөн, хөрвөх сонирхолтой мэргэжилтэнд зориулсан анги байх нь илүү давуу тал байж болохоор харагдаж байна.



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ
БОЛОВСРОЛ СУДИАЛЫН СУРГУУЛЬ

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Бага тойруу, Утас: 7012 0013, <http://www.msue.edu.mn>

2020.06.02 № 1/51
танай _____-ны № _____-т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНД

Шинжээчийн тайлантай танилцсан
тухай

Багш, насан туршийн боловсрол /D011405/ хөтөлбөрт хийсэн шинжээчийн үнэлгээний тайлантай уншиж танилцаад үнэлгээ, зөвлөмжтэй санал бүрэн нийцэж байна.

Цаашид өгсөн заавар, зөвлөмжийн дагуу "Багш, насан туршийн боловсрол"-ын хөтөлбөрийг тасралтгүй засаж, сайжруулах төлөвлөгөө гарган, тайланд тусгагдсан зөвлөмж, анхаарах зүйлс, дүгнэлтийн дагуу хөтөлбөрийн тасралтгүй хөгжлийг ханган ажиллах болно.

ЗАХИРАЛ, ДЭД ПРОФЕССОР *Т. Цогзолмаа* ЦОГЗОЛМАА



202009102

ХАВСРАЛТ 1

Монгол улсын боловсролын их сургуулийн Боловсрол судлалын сургуулийн Багш, насан туршийн боловсрол бакалаврын хөтөлбөрт ажиллах шинжээчдийн ажлын хуваарь

Огноо: 2020-05-12
2020-05-13

09.00-15.00 цаг
09.30-16.20 цаг

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн
2020-05-12 Мягмар гараг /Сургууль дээр/		
09:00-09:30	Шинжээчийн баг өөрийн үнэлгээний багийн удирдлагатай уулзана.	Шинжээчийн баг, өөрийн үнэлгээний баг
	Шинжээчийн багийн ахлагч үг хэлнэ. - Магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулах	Шинжээчийн багийн ахлагч
	Өөрийн үнэлгээний багийн ахлагч, хөтөлбөрийн талаар танилцуулга хийнэ. /сургуулийн орчин, лаборатори, номын сангийн зураг, мэдээллийг багцлан харуулах гэх мэт/	Өөрийн үнэлгээний багийн ахлагч
	Асуулт, хариулт	Шинжээчийн баг, өөрийн үнэлгээний баг
09:30-10:10	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчинтой танилцана.	Шинжээчид
10:10-15:00	Илрэл нотолгоотой танилцана.	Шинжээчид
2020-05-13 Лхагва гараг /Сургууль дээр/		
09:30-10:00	Онлайн уулзалтын бэлтгэлийг хангах	Шинжээчид, Мэргэжилтэн
10:00-10:40	Ажил олгогчидтой хийх уулзалт /ZOOM гэх мэт/	
10:40-11:00	Завсарлага	
11:00-11:40	Төгсөгчидтэй хийх уулзалт /ZOOM гэх мэт/	
11:40-13:00	Завсарлага	
13:00-13:40	Оюутантай хийх уулзалт /ZOOM гэх мэт/	
13:40-14:00	Завсарлага	
14:00-14:40	Багш нартай хийх уулзалт	Шинжээчид
15:00-15:40	Шинжээчийн багийн уулзалт, Урьдчилсан дүгнэлтээ ярилцаж, бичих	
16:00-16:20	Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багт урьдчилсан дүгнэлтийг танилцуулна.	Өөрийн үнэлгээний баг, шинжээчийн баг

Хуваарь гаргасан: Мэргэжилтэн Б.Оюунчимэг